


“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААР:

2019 онд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлтийн хувьд Диспетчерийн графикийг бүрэн биелүүлж ажилласан. 2019 онд 1,054.3 сая.кВтц ЦЭХ боловсруулж, төлөвлөгөөг **101.4%**-иар биелүүлсэн. ЦЭХ-ний боловсруулалт төлөвлөгөөнөөс 14.2 сая.кВтц-аар өсч, урьд оны мөн үетэй харьцуулахад 30.7 сая.кВтц-аар буурсан үзүүлэлттэй байна.

| Үзүүлэлт | | Хэмжих нэгж | 2018 оны гүйцэтгэл | 2019 он | | Зөрүү | |
|------------------------|---------------|-------------|--------------------|---------|---------------|----------|------------|
| | | | | Төл-гөө | Гүйц-л | гүйц-төл | гүйц-өм.он |
| Дундаж цахилгаан чадал | | МВт | 123.9 | 118.7 | 120.4 | 1.6 | -3.5 |
| Цахилгаан эрчим хүч | Боловсруулалт | Сая.кВтц | 1085.0 | 1040.1 | 1054.3 | 14.2 | -30.7 |
| | Түгээлт | | 905.5 | 867.5 | 881.0 | 13.5 | -24.5 |
| | ДХЦЭХ | % | 179.5 | 172.6 | 173.3 | 0.7 | -6.2 |
| Дулааны эрчим хүч | Усаар | мян.Гкал | 1910.2 | 1960.2 | 1939.7 | -20.5 | 29.5 |
| | Уураар | | 282.5 | 261.5 | 274.5 | 13.0 | -8.0 |
| | Нийт | | 2192.7 | 2221.7 | 2214.2 | -7.5 | 21.5 |
| ЖТХЗ | Цахилгаанд | гр/кВтц | 317.4 | 308.3 | 314.3 | 6.0 | -3.1 |
| | Дулаанд | кг/Гкал | 175.8 | 175.3 | 176.0 | 0.7 | 0.2 |

2019 оны ЦЭХ-ний боловсруулалт, түгээлт




Цахилгаан эрчим хүчний түгээлт:

Тус компани 2019 онд 1054.3 сая кВтц цахилгаан эрчим хүч боловсруулснаас дотоод хэрэгцээндээ 173.3 сая кВтц буюу 16.44 %-ийг зарцуулан 881.0 сая кВтц цахилгаан эрчим хүч түгээж анхны төлөвлөгөөг

101.4 %-аар биелүүллээ. Нийт түгээсэн цахилгаан эрчим хүчний 98.4%-ийг “ДҮТ” ХХК-д, 0.5%-ийг өөрийн шиний түгээлт, 1.1%-ийг үйлдвэрлэлийн бус хэрэглээнд тооцогдсон энерги тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд түгээсэн цахилгаан эрчим хүчийг төлөвлөгөөтэй харьцуулахад 13.5 сая кВтц-аар буюу 1.6%-иар нэмэгдэж, өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 24.5 сая кВтц-аар буюу 2.7%-иар буурсан байна.

2019 оны нийт ЦЭХ-ний түгээлт 881 сая.кВтц



ЦЭХ түгээлтийн хэмжээ өмнөх оны гүйцэтгэлээс буурахад нөлөөлсөн гол хүчин зүйлсийг авч үзье.


- ТБЭХС-ийн хэрэглээ, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаатай холбоотойгоор 01, 02, 03-р саруудад ЦЭХ түгээлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс буурч төлөвлөгдсөн бөгөөд тус саруудад ЦЭХ түгээлт өмнө оны мөн үетэй харьцуулахад 16.9 сая кВтц-аар буурсан.
- Дунд даралтын станцын бүрэн зогсолт 2019 онд 06 сарын 01-ны өдрөөс эхлэн 92 хоногийн хугацаанд үргэлжилсэн нь өмнөх оны мөн үеэс 30 хоногоор нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор 06-р сард ЦЭХ түгээлт 19 сая кВтц-аар буурсан.

Дулааны эрчим хүч түгээлт:

2019 онд 4176.9 мянган Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн, уураар 274.5 мянган Гкал, усаар 1939.7 мянган Гкал, нийт 2214.2 мянган Гкал дулааны эрчим хүч түгээж анхны төлөвлөгөөг усаар 98.9%, уураар 105.0%, нийт дулаан түгээлтийг 99.7%-аар биелүүлж ажиллалаа.

“УБДС” ТӨХК-нд түгээсэн дулааны эрчим хүч төлөвлөгөөнөөс 21.1 мянган Гкал-аар буурч, өмнөх жилийн гүйцэтгэлээс 29.2 мянган Гкал-аар

нэмэгдсэн байна. Дулааны эрчим хүчний диспетчерийн графикийг 100% биелүүлэн ажилласан боловч үйлдвэрлэлийн төлөвлөгөөнөөс сүлжээний усны зарцуулалт 49 тн/ц-аар, халалт 1.8 °C-ээр тус тус буурсан нь дулааны эрчим хүч түгээлтийн төлөвлөгөө 21.1 мянган Гкал-аар буурахад нөлөөлсөн байна.



ДХЦЭХ: ДХЦЭХ-ний хэмжээ 2019 онд 173.3 сая кВт.ц буюу 16.44% байгаа нь төлөвлөгөөт хэмжээнээс 0.16%-аар, өмнөх оны мөн үеэс 0.1%-аар тус тус буурсан байна.

| Үзүүлэлт | Нэгж | 2018 оны гүйц | 2019 он | | Зөрүү | |
|--|-----------|---------------|---------|---------------|----------|------------|
| | | | Төл | Гүйц | Гүйц-төл | Гүйц-өм.он |
| Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч | сая кВт.ц | 179.5 | 172.6 | 173.3 | 0.7 | -6.2 |
| | Хувь | 16.54% | 16.60% | 16.44% | -0.16% | -0.10% |

- Төлөвлөгөөт хэмжээнээс ДХЦЭХ-ний хувь хэмжээ 0.16%-аар буурахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна.
 - ДҮТ ХХК-аас өгөгдсөн графикийн дагуу тус онд төлөвлөгөөнөөс 13.5 сая кВтц ЦЭХ илүү түгээсэн байна.
 - ДЭХ түгээлтийн хэмжээ 7.5 мянган Гкал-аар буурсан.
 - Зуух №9-ын ДВ болон ДМ-ын хөдөлгүүрт инвертор суурилуулан ашигласнаар ДХЦЭХ-ний хэмжээ 681.0 мян.кВтц-аар буурсан.
 - Өндөр даралтын станцын тэжээлийн усны хувьсах зарцуулалтын насосны ашиглалтын хугацааг нэмэгдүүлсэн . Тус насос 2019 онд 7234 цаг ажилласан нь өмнөх оноос 470 цагаар нэмэгдсэн байна.

Жишмэл түлшний хувийн зарцуулалт:

Нэгж эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд 314.3 гр/кВтц, дулаанд 176.0 кг/Гкал байгаа нь төлөвлөгөөтэй харьцуулахад цахилгаанд 6.0 гр/кВтц-аар, дулаанд 0.7 кг/Гкал-аар тус тус нэмэгдсэн байна.

Жишмэл түлшний хувийн зарцуулалтын хэмжээг төлөвлөгөө болон өмнөх онтой харьцуулан дараах хүснэгтэнд харууллаа.

| Жишмэл түлшний хувийн зарцуулалт | Нэгж | 2018 оны гүйцэтгэл | 2019 он | | Зөрүү | |
|----------------------------------|---------|--------------------|-----------|--------------|-----------|------------|
| | | | Төлөв-гөө | Гүйц-л | гүйц- төл | гүйц-өм.он |
| Цахилгаанд | гр/кВтц | 317.4 | 308.3 | 314.3 | 6.0 | -3.1 |
| Дулаанд | кг/Гкал | 175.8 | 175.3 | 176.0 | 0.7 | 0.2 |

Жишмэл түлшний хувийн зарцуулалт төлөвлөгөөнөөс нэмэгдэх, өмнөх оны мөн үеэс буурахад нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар авч үзье.

➤ ТГ №9-ын урсгал засварын ажил:

ТГ №9-ын урсгал засварын ажлыг VI/01-VI/18-ны хооронд 18 хоногт хийхээр төлөвлөсөн боловч засварын ажил 27 хоногийн хугацаанд үргэлжилсэн. Нэгжийн хүчин чадал өндөртэй ТГ №9 төлөвлөснөөс удаан хугацаанд засварт зогссон нь цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ болон жишмэл түлшний хувийн зарцуулалтыг нэмэгдэхэд нөлөөлсөн. Урсгал засварын хугацаанд буюу 06-р сард жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд төлөвлөгөөнөөс 34.2 гр/кВтц-аар нэмэгдсэн.

➤ ДЭХ түгээлтийн бууралт:

Дараах хүснэгтэнд дулааны горимоор боловсруулсан ЦЭХ-ний хэмжээ, ДЭХ түгээлтийн хэмжээ болон РОУ-ын зарцуулалтыг харууллаа.

| Үзүүлэлт | нэгж | 2018 оны гүйцэтгэл | 2019 оны төлөвлөгөө | 2019 оны гүйцэтгэл | зөрүү | | |
|------------------------------------|------------|--------------------|---------------------|--------------------|--------------|------------|------|
| | | | | | гүйц-төл | гүйц-өм.он | |
| ЦЭХ боловсруулалт | сая кВтц | 1085 | 1040.1 | 1054.3 | 14.2 | -30.7 | |
| Дулааны горимоор боловсруулсан ЦЭХ | сая кВтц | 602.6 | 592.9 | 593.7 | 0.8 | -8.9 | |
| | % | 55.5% | 57.0% | 56.3% | 0.7% | 0.8% | |
| ДЭХ түгээлт | мян.Гкал | 2192.7 | 2221.7 | 2214.2 | -7.5 | 21.5 | |
| РОУ-ын зарцуулалт | мян.тн | 187.1 | 130.8 | 159.6 | 28.8 | -27.5 | |
| ЖТХЗ | Цахилгаанд | гр/кВтц | 317.4 | 308.3 | 314.3 | 6.0 | -3.1 |
| | Дулаанд | кг/Гкал | 175.8 | 175.3 | 176.1 | 0.8 | 0.3 |

2019 онд ДЭХ түгээлтийн хэмжээ төлөвлөгөөнөөс 7.5 мянган Гкал-аар буурсан боловч нэмэлтээр РОУ-ын ачаалалтай ажилладаг 1, 2 болон 11, 12-р саруудад ДЭХ түгээлтийн хэмжээ төлөвлөснөөс нэмэгдэж, дан турбины тохируулгатай авлагаас ДЭХ түгээдэг 3-р сараас 9-р саруудын хооронд төлөвлөгөөнөөс буурсан нь хослон үйлдвэрлэлийн хувь хэмжээг бууруулах, РОУ-ын ачааллыг нэмэгдүүлэхэд гол нөлөө үзүүлсэн.

Дараах хүснэгтэнд 2019 оны ДЭХ түгээлтийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийг нэмэлтээр РОУ-ын ачаалалтай ажилласан болон дан турбины тохируулгатай авлагаас хангаж ажилласан саруудаар ангилан харууллаа.

| Үзүүлэлт | ДЭХ түгээлтийн хэмжээ, мян.Гкал | |
|------------|---------------------------------|-------|
| | I, II, XI, XII | III÷X |
| Төлөвлөгөө | 1535.4 | 686.3 |
| Гүйцэтгэл | 1539.4 | 674.8 |
| Зөрүү | 4.0 | -11.5 |

Дан турбины отбороос ДЭХ түгээдэг саруудад түгээлтийн хэмжээ төлөвлөгөөнөөс 11.5 мянган Гкал-аар буурсан байна. Энэ нь дулааны горимоор боловсруулсан.

ЦЭХ-ийг 2.4 сая кВтц-аар бууруулсан байна. Мөн жилийн дулааны горимоор боловсруулах ЦЭХ-ний хувь хэмжээг 0.2%-аар бууруулсан байна.

II. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР:


1. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар

/сая төгрөгөөр/

| Д-Д | Үзүүлэлт | | Хэмжих нэгж | 2019 он | | |
|-----|-----------------------------------|----------------|----------------|------------------|------------------|--------------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| 1.1 | Бүтээгдэхүүний орлого | | сая.төг | 115,309.5 | 115,881.0 | 571.5 |
| | Үүнээс | ЦЭХ-ний орлого | сая.төг | 90,612.8 | 91,363.3 | 750.5 |
| | | ДЭХ-ний орлого | сая.төг | 24,696.7 | 24,517.7 | -179.0 |
| | Үүнээс | Уурын | сая.төг | 4,266.0 | 4,194.6 | -71.4 |
| | | Усны | сая.төг | 19,796.5 | 19,590.8 | -205.7 |
| | | Дулаан зөөгч | сая.төг | 634.2 | 732.4 | 98.1 |
| 1.2 | Үйл ажиллагааны бус орлого | | сая.төг | 929.8 | 1,023.5 | 93.6 |
| 1 | Нийт орлого | | сая.төг | 116,239.3 | 116,904.5 | 665.1 |

| | | | | | |
|--|--|--|--|--|--|
| | | | | | |
|--|--|--|--|--|--|

2019 он Нийт орлого 116,904.5 мян.төг



Нийт **116,904.5** сая.төгрөгийн орлоготой ажиллаж, орлого төлөвлөснөөс **665.1** сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс **2,789.4** сая төгрөгөөр өссөн байна.

Бүтээгдэхүүний борлуулалтын орлого **115,880.9** сая төгрөг ба төлөвлөснөөс **571.5** сая төгрөгөөр өссөн.

ЦЭХ-ний орлого төлөвлөгөөнөөс **750.5** сая төгрөгөөр өсөж, ДЭХ-ний орлого **178.9** сая төгрөгөөр буурсан байна.

ЦЭХ-ний орлогын нөлөөлөл

| | Тайлбар | Эерэг | Сөрөг |
|------------|--|--------------|--------------|
| | Үнэ тарифын өөрчлөлтөөс | 0.0 | 0.0 |
| 2. Түгээлт | ДҮТ ХХК-тай тооцох ЦЭХ-ний түгээлт 7,220.7 мян.квтц-аар өссөнөөр | 290.5 | |
| | Өрсөлдөөнт зах зээлд борлуулсан ЦЭХ 5,256.0 мян.квтц-р өссөнөөр | 317.3 | |
| | Өөрийн шинээс аж ахуйн нэгжид түгээсэн ЦЭХ-ний түгээлт 9.4 мян.квтц-аар нэмэгдсэнээр | 8.2 | |
| | Чадлын төлбөр тооцох түгээлт 2,735.9 мян.квтц-аар буурсанаар | | -24.6 |
| | Өөрийн хэрэгцээ 1,017.0 мян.квтц-аар нэмэгдсэнээр | 135.9 | |
| | Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифын орлого | 13.0 | |
| | Спот зах зээлээс олсон орлого | 10.3 | |
| | | 775.1 | -24.6 |
| | НИЙТ ДҮН | 775.1 | -24.6 |
| | Цахилгаан эрчим хүчний нийт орлогын өөрчлөлт | 750.5 | |

ДЭХ-ний орлогын нөлөөлөл

| Тайлбар | | Эерэг | Сөрөг |
|---|---|--------------|---------------|
| ҮНЭ ТАРИФИЙН ӨӨРЧЛӨЛТӨӨС | | 0.0 | 0.0 |
| 2. Түгээлт | УБДС ТӨХК-д түгээсэн ДЭХ 21.1 мян.Гкал-аар буурснаар | | 217.0 |
| | Өөрийн түгээсэн ДЭХ 540 Гкал-аар өссөнөөр | 11.3 | |
| | Хэрэглэгчдэд бичсэн уур түгээлт 2.2 мян.Гкал-аар буурсанаар | | 71.4 |
| | Бусад орлого /дулаан зөөгчийн орлого/ | 98.1 | |
| ТОО ХЭМЖЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТӨӨС | | 109.5 | 288.4 |
| Нийт дүн | | 109.5 | 288.4 |
| Дулааны эрчим хүчний нийт орлогын өөрчлөлт | | | -179.0 |


Үндсэн бус үйл ажиллагаанаас 1023.5 сая төгрөг орсон нь төлөвлөгөөнөөс 93.6 сая төгрөгөөр өссөн байна.Үүнд:

Банкны хүүгийн орлого 170.3 сая төгрөг, түрээсийн болон байрны орлого 108.7 сая, тендерийн орлого 13.6 сая төгрөг, ажил үйлчилгээний орлого 144.9 сая төгрөг, материал, хуучин сэлбэг материал борлуулсаны орлого 221.3 сая төгрөг, үндсэн хөрөнгө данснаас хассаны олз 25.3 сая.төг, алданги торгууль 45.4 сая төгрөг, валютын бодит бус ашиг 4.03 сая төгрөг, бусад 274.2 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлого тус тус орсон байна.

2. Зардлын төлөвлөгөөний биелэлтийн талаар:

2019 оны нийт **119,589.4** сая төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөснөөс 3,350.0 сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4,435.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үндсэн үйл ажиллагаанд **118,754.9** сая төгрөг зарцуулж, төлөвлөснөөс 3,149.3 сая төгрөгөөр хэтэрсэн.

2019 он Нийт зардал 119,589.3 мян.төг



Нийт зардалд түлшний зардал 47.2%, цалингийн зардал 22%, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 17.5%, бусад тогтмол зардал 12.6%, үйл ажиллагааны бусад зардал 0.7%-ийг тус тус эзэлж байна.

Тухайн онд Хувьсах зардал төлөвлөснөөс 1,187.4 сая төгрөгөөр, тогтмол зардал 1,961.8 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал 200.7 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн. Хэтэрсэн зардлыг ангилж үзвэл:

Хэтэрсэн зардал

/мянган төгрөгөөр/

| д/д | Зардлын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|-----|------------------------------|---------------------|---------------------|--------------------|
| 1 | Түлшний зардал | 55,270,873.6 | 56,458,299.3 | 1,187,425.7 |
| 2 | Цахилгаан, дулааны зардал | 1,394,493.6 | 1,429,094.6 | 34,601.0 |
| 3 | Урсгал засвар | 1,567,674.2 | 1,645,739.9 | 78,065.8 |
| 4 | Хангамжийн материал | 105,192.7 | 112,085.7 | 6,893.0 |
| 5 | ДҮТ-ийн зохицуулалтын зардал | 10,529.9 | 14,640.1 | 4,110.2 |
| 6 | Бүтээмжийн зардал | 32,400.0 | 35,384.4 | 2,984.4 |
| 7 | Үндсэн хөрөнгийн элэгдэл | 18,292,863.2 | 20,968,575.0 | 2,675,711.8 |
| 8 | Үл хөдлөх хөрөнгийн татвар | 591,698.3 | 601,277.2 | 9,578.8 |
| 9 | Агаарын бохирдлын татвар | 0.0 | 42,586.3 | 42,586.3 |
| 10 | АНЗардал | 2,642,718.3 | 2,921,495.1 | 278,776.9 |
| 11 | Үйл ажиллагааны бус зардал | 633,673.8 | 834,417.9 | 200,744.1 |
| | Нийт зардлын дүн | 80,542,117.6 | 85,063,595.6 | 4,521,478.0 |

Түлшний зардал -2019 онд түлшний зардал 1,187.4 сая төгрөгөөр хэтэрсэн.

- ЦЭХ-ний түгээлтийн төлөвлөгөө 13.5 сая кВт.ц-аар нэмэгдсэнээр түлшний зардал 150.0 сая төгрөгөөр өссөн.
- ДЭХ-ний түгээлтийн төлөвлөгөө 7.5 мян.Гкал-р буурснаар түлшний зардал 105.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн.
- ЖТХЗ-ын хэтрэлтээс /ЦЭХ- 13,736.6тн, ДЭХ- 3,393.7тн/ 539.6 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Багануурын нүүрсний үнийн 2000 төгрөгний нэмэгдлээс 1,155.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Илчлэгийн үнийн зөрүүгээр 76.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Төмөр замын тээврийн хөлс 46.1 сая төгрөгөөр хэмнэсэн.
- Бусад зардал 199.6 сая төгрөгөөр хэмнэсэн.
- Мазут 353.6 сая төгрөгөөр, дизелийн түлш 29.3 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Урсгал засварын зардал - Тээрмийн ган бөмбөлөг болон бусад бараа материалын зах зээл дээрх төмрийн үнийн өсөлт болон валютын ханшны зөрүүнээс шалтгаалж урсгал засвар төлөвлөснөөс 78.0 сая төгрөг хэтэрсэн.

Хангамжийн зардал- 2019 оны 12-р сард Цахилгаан цех захиалгын хуудсаар тестер FLUKE 2 ширхэгийг авсанаар хангамжийн зардал өссөн дүнгээр 6.8 сая төгрөгөөр хэтэрсэн.

Үндсэн хөрөнгийн элэгдэл- ТӨБЗГ-ын шийдвэрээр 2018 онд Үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлж санхүүгийн тайланд тусгасан. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн элэгдэл нэмэгдсэнээр үндсэн хөрөнгийн элэгдэл гүйцэтгэлээр 20,968.6 сая төгрөг гарч төлөвлөснөөс 2,675.7 сая төгрөгөөр хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Цахилгааны зардал- 2019 онд трансформаторын алдагдал төлөвлөснөөс 750.7 мян.кВтц, үйлдвэрлэлийн бус цехүүдийн хэрэглээ 266.3 мян.кВтц хэтэрч нийт өөрийн хэрэгцээ 1017.0 мян.кВтц хэтэрсэнээс цахилгааны зардал 34.6 сая.төгрөг хэтэрсэн.

АНЗ-Тэтгэвэрт суух 30 хүн төлөвлөснөөс 2019 оны гүйцэтгэлээр 36 хүн сууснаас шалтгаалж тэтгэвэр тэтгэмжийн зардал 113.4 сая төгрөг, 2019 онд 3 удаа үйлдвэрлэлийн осол гарч нөхөн олговорт 179.8 сая төгрөг олгосноор Ажилтны нийгмийн зардал 278.7 сая төгрөгөөр хэтэрсэн.

ҮАБЗ- ТЕГ, ТӨБЗГ, Үндэсний аудитын газрын хяналт шалгалтын актын төлбөр 150.3 сая төгрөгөөр, борлуулсан материалын өртөг 8.1 сая төгрөг, тендерийн зардал 3.4 сая төгрөг, олимпийн байрны зардал 6.9 сая төгрөг, түрээсийн зардал 27.7 сая төгрөг, цайны газар 3.6 сая төгрөг, ҮЭХ-ний зардал 3.3 сая төгрөг, ахмадын сан 7.9 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн.

3.Ашиг алдагдлын талаар:

2019 онд ашиг алдагдалгүй байхаар төлөвлөж гүйцэтгэлээр -2,684.9 сая.төгрөгийн алдагдалтай ажилласан.


| Д.Д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2019 он | | |
|------------|-----------------------------------|----------------|------------------|------------------|-----------------|
| | | | Төлөв | Гүйц | Өссөн дүнгээр |
| 1.1 | Бүтээгдэхүүний орлого | сая.төг | 115,309.5 | 115,881.0 | 571.5 |
| | Үүнээс | | | | |
| | ЦЭХ-ний орлого | сая.төг | 90,612.8 | 91,363.3 | 750.5 |
| | ДЭХ-ний орлого | сая.төг | 24,696.7 | 24,517.7 | -179.0 |
| | Үүнээс | | | | |
| | Уурын | сая.төг | 4,266.0 | 4,194.6 | -71.4 |
| | Усны | сая.төг | 19,796.5 | 19,590.8 | -205.7 |
| | Дулаан зөөгч | сая.төг | 634.2 | 732.4 | 98.1 |
| 1.2 | Үйл ажиллагааны бус орлого | сая.төг | 929.8 | 1,023.5 | 93.6 |
| 1 | Нийт орлого | сая.төг | 116,239.3 | 116,904.5 | 665.1 |
| 2.1 | Үйл ажиллагааны зардал | сая.төг | 115,605.7 | 118,755.0 | 3,149.3 |
| 2.2 | Үйл ажиллагааны бус зардал | сая.төг | 633.7 | 834.4 | 200.7 |
| 2 | Нийт зардал | сая.төг | 116,239.3 | 119,589.4 | 3,350.0 |
| 3 | Нийт ашиг/алд | сая.төг | 0.0 | -2,684.9 | -2,684.9 |

4. Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал

Зардал хэтэрсэнээс шалтгаалж Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал төлөвлөснөөс 0.02 төгрөгөөр өссөн.

ЦЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 76.12 төгрөг байгаа ба 1 кВтц ЦЭХ-ийг дунджаар 103.71 төгрөгөөр борлуулж, нэгжээс 27.59 төгрөгийн, нийт ЦЭХ-ний үйлдвэрлэлтээс 24,305.3 сая төгрөгийн ашигтай ажилласан.

2019 оны ашиг, алдагдал



ДЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 23,347.84 төгрөг байгаа ба 1 Гкал ДЭХ-ийг дунджаар 11,072.9 төгрөгөөр борлуулсан нь нэгжээс 12,284.9 төгрөгийн, нийт ДЭХ үйлдвэрлэлтээс 27,179.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үйл ажиллагааны бус ашиг 2019 оны гүйцэтгэлээр 189.1 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 107.1 сая.төгрөгөөр буурсан байна.

5. Нийт авлага

Компани 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 8.6 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдлийг төрөл тус бүрээр нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал:

| Үзүүлэлт | 2018.12.31 | 2019 оны зорилтот түвшин | 2019.12.31 | Өөрчлөлт | |
|-------------------------|----------------|--------------------------|----------------|-----------------------|----------------------------|
| | | | | Өнгөрсөн оны мөн үеэс | 2019 оны зорилтот түвшнээс |
| ДҮТ ТӨХК | 5,296.7 | 5,800.0 | 8,214.9 | 2,918.2 | 2,414.9 |
| УБДС ТӨХК | 2,713.1 | 1,600.0 | 67.1 | -2,646.0 | -1,532.9 |
| Уурын борлуулалт | 218.8 | 210.0 | 106.6 | -112.2 | -103.4 |
| Өөрийн шиний борлуулалт | 40.5 | 50.0 | 20.7 | -19.9 | -29.4 |
| Албан байгууллага | 18.8 | 20.0 | 36.5 | 17.7 | 16.5 |
| Татвар | 18.7 | 0.0 | 53.3 | 34.6 | 53.3 |
| Бусад авлага | 66.5 | 60.0 | 68.7 | 2.2 | 8.7 |
| Дүн | 8,373.1 | 7,740.0 | 8,562.5 | 189.4 | 822.5 |

2019 онд нийт авлага оны эхнээс 189.4 сая төгрөгөөр, зорилтот түвшний төлөвлөгөөнөөс 822.5 сая төгрөгөөр өссөн байна.

ДҮТ ТӨХК-ийн авлага өнгөрсөн оны мөн үеийнхээс 2,918.2 сая төгрөгөөр, зорилтот түвшний үзүүлэлтээс 2,414.9 сая төгрөг өсч цахилгаан борлуулалтын орлого төвлөрүүлэх төлөвлөгөө 97.0%-иар биелсэн.

УБДС ТӨХК нь өмнө онд үүссэн 2,713.1 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан. УБДС ТӨХК-д НӨТ-тэй дүнгээр 21,480.9 сая төгрөгний ДЭХ-ийг борлуулж 24,126.8 сая төгрөгний төлбөр хийж борлуулалтын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөг 112.3%-иар биелүүлсэн байна.

6.Нийт өглөг

Нийт өглөгийн үлдэгдэл 34,060.3 сая төгрөг байгаа нь зорилтот түвшинд төлөвлөсөн нийт өглөгийн үлдэгдлээс 2,066.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

| Төрөл | 2018.12.31 | 2019 оны Зорилтот түвшин | 2019.12.31 | Өөрчлөлт | |
|--|-----------------|--------------------------------|-----------------|-----------------------------|----------------------------------|
| | | | | Өнгөрсөн оны мөн үеэс | 2019 оны зорилтот түвшнээс |
| БН-дэд төлөх өр | 3,029.9 | 5,500.0 | 9,939.8 | 6,909.9 | 4,438.8 |
| Татвар, НДШ өр | 279.3 | 0.0 | 139.3 | -140.0 | 139.3 |
| Урт хугацаат зээлийн үндсэн төлбөр, хүү | 1,938.1 | 1,933.5 | 1,934.9 | -3.2 | 1.4 |
| УБДС ТӨХК | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Жилийн үр дүнгийн шагнал | 2,908.4 | 2,700.0 | 0.0 | -2,908.4 | -2,700.0 |
| Бусад өглөг | 76.1 | 70.0 | 190.6 | 114.5 | 120.6 |
| Урьдчилж орсон орлого | 3.1 | 10.0 | 4.8 | 1.7 | -5.2 |
| Богино хугацаат өглөгийн дүн | 8,234.9 | 10,213.5 | 12,209.4 | 3,974.5 | 1,995.9 |
| Урт хугацаат өглөг | 23,934.0 | 21,779.9 | 21,850.9 | -2,083.1 | 71.0 |
| НИЙТ ӨГЛӨГ | 32,168.9 | 31,993.4 | 34,060.3 | 1,891.4 | 2,066.9 |

Нийт өглөгийн 35.9%-ийг богино хугацаат өр төлбөр, 64.1%-ийг урт хугацаат зээлийн өр эзэлж байна.

Богино хугацаат өглөг өнгөрсөн оны мөн үеийнхээс 48.2 % буюу 3,974.5 сая төгрөгөөр, зорилтот түвшний үзүүлэлтээс 1,995.9 сая.төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

2019 онд ДҮТ ТӨХК-иас авах авлага 2,414.9 сая төгрөгөөр нэмэгдсэнээр бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын өр төлбөрийг барагдуулж чадсангүй өглөг өссөн.

7. Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажил

сая.төгрөгөөр

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|-----------------------------|-----------------|-----------------|-----------------|
| Үндсэн тоноглолын их засвар | 9,154.7 | 7,664.2 | -1,490.5 |
| Туслах тоноглолын их засвар | 4,434.6 | 3,342.7 | -1,091.9 |
| Барилгын их засвар | 660.6 | 626.1 | -34.5 |
| ТЗБАХ | 6,325.2 | 1,889.0 | -4,436.2 |
| Хөрөнгө оруулалт | 1,800.2 | 930.0 | -870.2 |
| Дүн | 22,375.3 | 14,452.0 | -7,923.3 |

ИЗ, ТЗБАХ, ХО-аар хийгдэх 10 ажил хугацаа хойшлогдсоноос шалтгаалж 6,089.4 сая.төг, бусад ажил төлөвлөснөөс 1,833.8 сая.төг хэмнэсэн үзүүлэлттэй байна.

| № | Ажлын нэр | Тайлбар | Дүн |
|-----------------|---|---|----------------|
| 1 | Турбогенератор №4-н роторын №3, 9, 10,11,12,13,14-р үеийн ажлын хүрээ, бандажыг солих | Энержистандарт ХХК-тай байгуулсан гэрээний дагуу агуулахад материал буусан. Ажил нь 2020 онд хийгдэнэ. | 800.0 |
| 2 | Үнсэн сан шинээр барих | Комфорт импекс ХХК-тай гэрээ байгуулсан. | 3,999.2 |
| 3 | С-50-8, 83-0, 294 турбины 20-р үеийн ажлын хүрэнүүд солих | Хунан индастриал экүйпмент инсталэйшн ХХК-тай байгуулсан гэрээний дагуу агуулахад материал буусан. Ажил нь хойшлогдсон. | 450.0 |
| 4 | ОРУ-110 хуурай салгууруудыг сольж шинэчлэх | Мон энерги ХХК-тай гэрээ байгуулсан. | 85.1 |
| 5 | ТГ-9-ийг АУРА-д оруулах | 2020 оны 2-р сард хийгдэж дууссан. | 27.1 |
| 6 | ӨДХ-ийн 110кВ-ын цэнэг шавхагчийг ОПН болгох | 2019 онд 3 удаа тендер зарлаад амжилтгүй болсон. 2020 оны 2-р сард Новатек ХХК-тай гэрээ байгуулсан. | 60.0 |
| 7 | Бага оврын дугуйт экскаватор | 2020 оны 1-р сард нийлүүлэгдсэн. | 250.0 |
| 8 | Алхан бутлагчийн цахилгаан хөдөлгүүр | 2020 оны 3-р сард нийлүүлэгдсэн. | 220.0 |
| 9 | Цахилгаан хөдөлгүүр /2ш/ | 2020 оны 2-р сард нийлүүлэгдсэн. | 60.0 |
| 10 | Цахилгаан ионжуулах төхөөрөмж | 2020 оны 1-р сард нийлүүлэгдсэн. | 138.0 |
| Нийт дүн | | | 6,089.4 |

8. Цалингийн талаар

- 2019 оны байдлаар орон тооны гүйцэтгэлээр 994 гарч 2 орон тоогоор хэмнэж ажилласан.
- Цалингийн сан 821.1 сая төгрөг хэмнэсэн. Үүнд: Хүний амь эрсдэж осол гарсантай холбоотойгоор 10-р сарын үр дүнгийн шагнал компанийн хэмжээнд олгогдоогүйгээс цалингийн зардал 514.6 сая төгрөг, дагалдан болон арга хэмжээ авсан ажилчдын сарын болон жилийн үр дүнгээс 297 сая төгрөг хэмнэсэн.
- Нэг ажилтны дундаж цалин 2,247,026.9 төгрөг байгаа нь төлөвлөснөөс 64,191.7 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Санхүү ня-бо бүртгэл:

2019 оны 12-р сарын 31-ний байдлаар тус компани нь 26,493.1 сая төгрөгийн эргэлтийн, 229,197.7 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй, 12,209.4 сая төгрөгийн богино хугацаат, 21,850.9 сая төгрөгийн урт хугацаат өртэй, 221,630.5 сая төгрөгийн эзэмшигчдийн өмчтэй нийтдээ 255,690.8 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

1. Мөнгөн хөрөнгө : Нийт мөнгөн орлого, зарлагын урсгалыг авч үзвэл:

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлтүүд | | 2018 | | 2019 | | Зөрүү | |
|-----------------------|-------------------------|------------------|-------------|------------------|-------------|----------------|-------------|
| | | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| Мөнгөний орох урсгал | ДҮТ ТӨХК | 76,970.9 | 72.1% | 84,993.3 | 73.5% | 8,022.4 | 10.4% |
| | УБДС ТӨХК | 21,684.6 | 20.3% | 23,262.4 | 20.1% | 1,577.8 | 7.3% |
| | Уурын борлуулалт | 5,334.0 | 5.0% | 5,532.3 | 4.8% | 198.3 | 3.7% |
| | Өөрийн щиний борлуулалт | 995.2 | 0.9% | 887.4 | 0.8% | -107.8 | -10.8% |
| | Бусад | 1,746.5 | 1.6% | 1,032.9 | 0.9% | -713.6 | -41% |
| | Нийт орох урсгал | 106,731.2 | 100% | 115,708.3 | 100% | 8,977.1 | 8.4% |
| Мөнгөний гарах урсгал | Цалин | 18,489.5 | 16.8% | 23,171.6 | 19.9% | 4,682.1 | 25.32% |
| | Сэлбэг материал, ҮХ | 11,852.9 | 10.8% | 15,941.4 | 13.7% | 4,088.5 | 34.49% |
| | Багануур ХК | 45,200.0 | 41.1% | 42,724.0 | 36.7% | 2,476.0 | -5.48% |
| | Их засварын хөлс | 10,481.6 | 9.5% | 8,269.9 | 7.1% | 2,211.7 | 21.10% |
| | НДШ | 5,981.0 | 5.4% | 7,475.5 | 6.4% | 1,494.5 | 24.99% |
| | НӨАТ | 3,550.9 | 3.2% | 4,732.0 | 4.1% | 1,181.1 | 33.26% |
| | Бусад татвар | 3,587.6 | 3.3% | 4,328.8 | 3.7% | 741.2 | 20.66% |
| | Зээл, зээлийн хүү | 265.3 | 0.2% | 281.6 | 0.2% | 16.3 | 6.14% |
| | Төмөр зам | 3,164.5 | 2.9% | 3,840.0 | 3.3% | 675.5 | 21.35% |

| | | | | | | |
|--------------------------|------------------|-------------|------------------|-------------|----------------|-------------|
| Бусад ажиллагааны зардал | 7,498.8 | 6.8% | 5,652.4 | 4.9% | - | - |
| Нийт гарах урсгал | 110,072.1 | 100% | 116,417.2 | 100% | 6,345.1 | 5.8% |

2019 онд касс болон харилцах дансанд нийтдээ 115.7 тэрбум төгрөг төвлөрсөн нь өнгөрсөн онохоос 9.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 73.5% буюу 85,0 тэрбум төгрөгийг ДҮТ ТӨХК-иас, 20,1 % буюу 23,3 тэрбум төгрөгийг УБДС ТӨХК-иас төвлөрүүлсэн байна.

Арилжааны банкуудаас дансны дундаж үлдэгдэлд олгосон хүүгийн орлогод 170,2 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлогыг оллоо.

Жилийн туршид 2136 орчим байгууллагад 116,4 тэрбум төгрөгийн төлбөрийг хийлээ. Мөнгөний хуваарилалтыг авч үзвэл нийт зарцуулалтын 36.7%-ийг буюу 42,7 тэрбум төгрөгийг Багануурын уурхайд, 7,1% буюу 8,3 тэрбум төгрөгийг их засварын ажлын хөлсөнд, 13,7% буюу 15,9 тэрбум төгрөгийг үндсэн хөрөнгө, сэлбэг, материалын үнэнд, 3,3% буюу 3,8 тэрбум төгрөгийг Төмөр замын зардалд тус тус төлжээ.

Төсөвт төлөх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу цаг тухайд нь төлж өр үүсгэлгүй ажиллалаа.

Татвар төлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулж үзвэл:

/сая төгрөгөөр/

| № | Татварын төрөл | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|-----------------|----------------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|
| 1 | ААНОАТатвар | 6.3 | 44.1 | 55.4 | 39.8 | 16.7 |
| 2 | НӨАТ | | | | | |
| | мөнгөөр | 3,522.1 | 3,200.6 | 3,540.0 | 3,424.0 | 4,732.1 |
| | хаалтаар | 909.9 | 1,970.3 | 1,082.8 | 966.8 | 1,105.6 |
| 3 | НДШ | 4,518.4 | 4,815.0 | 6,131.6 | 5,982.0 | 7,457.6 |
| 4 | ХХОАТатварт | 1,749.6 | 2,079.1 | 2,620.1 | 2,131.9 | 2,524.0 |
| 5 | ҮХХ-ийн татварт | 351.6 | 557.6 | 570.1 | 579.9 | 591.7 |
| 6 | Газрын төлбөр | 116.0 | 146.0 | 146.0 | 147.2 | 299.7 |
| 7 | Усны нөөц ашигласны төлбөр | 416.0 | 361.1 | 395.8 | 405.5 | 435.1 |
| 8 | АТӨЯХАТатвар | 1.2 | 1.2 | 1.2 | 1.9 | 1.4 |
| 9 | Агаарын бохирдлын татвар | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 |
| 10 | Авто зам ашигласны татвар | 0.9 | 0.9 | 0.9 | 1.5 | 1.0 |
| НИЙТ ДҮН | | 11,592.1 | 13,176.0 | 14,544.0 | 13,680.6 | 17,165.1 |

2019 онд 17,165.1 сая төгрөгийн татвар, шимтгэлийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өнгөрсөн оныхоос 3,484.5 сая төгрөгөөр өссөн байна.


2.Материалын талаар:

Бараа материалын эхний үлдэгдэл, орлого, зарцуулалт, эцсийн үлдэгдлийг нэр төрөл тус бүрээр нь авч үзвэл:

/сая төгрөгөөр/

| Төрөл | Эхний үлдэгдэл 2019-01-01 | Орлого | Зарлага | Эцсийн үлдэгдэл 2019-12-31 | Өөрчлөлт |
|-------------------|---------------------------|-----------------|-----------------|----------------------------|----------------|
| Нүүрс | 2,754.6 | 55,625.1 | 55,105.3 | 3,274.4 | 519.8 |
| Мазут | 1,531.7 | 1,610.2 | 1,323.3 | 1,818.6 | 286.9 |
| Дизель түлш, тос | 207.4 | 613.0 | 554.0 | 266.5 | 59.1 |
| Химийн материал | 124.3 | 370.0 | 349.5 | 144.8 | 20.5 |
| 9-р зуухны сэлбэг | 1,126.3 | 0.0 | 15.3 | 1,111.0 | -15.3 |
| Сэлбэг материал | 4,302.6 | 5,287.7 | 4,556.5 | 5,033.9 | 731.3 |
| Бусад бараа | 216.5 | 779.7 | 773.2 | 223.0 | 6.5 |
| Дүн | 10,263.4 | 64,285.7 | 62,677.1 | 11,872.2 | 1,608.8 |

Жилдээ 64,285.7 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч 62,677.1 сая төгрөгийн бараа материалыг үйлдвэрлэлд зарцуулан 11,872.2 сая төгрөгийн материалын үлдэгдэлтэй гарсан нь оны эхнээс үлдэгдлийг 1,608.8 сая төгрөгөөр өсгөсөн байна. 9-р зуухны сэлбэг 15.3 сая төгрөгөөр буурсан байна.



Бараа материалын үлдэгдлийн 28%-ийг нүүрс, 42%-ийг агуулахын сэлбэг материал, 9%-ийг 9-р зуухны сэлбэг материал, 15%-ийг мазутын үлдэгдэл эзэлж байна.

2019 онд 1,314.7 мянган тонн нүүрс хүлээн авч 1,306.2 мянган тонныг зарцуулж 76.0 мянган тонн нүүрс талбай дээр үлдсэн нь өнгөрсөн оны үлдэгдлээс

Биет хэмжээгээр 8.6 мянган тонноор өссөн байна. Мазутын үлдэгдэл 1228.8 тн байна.

3. Үндсэн хөрөнгө:

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг авч үзвэл:

/сая төгрөгөөр/

| № | Хөрөнгийн төрөл | 12/31/2018 | | 12/31/2019 | | Өөрчлөлт | |
|-----------------------|--|-------------------|---------------|-------------------|---------------|------------------|---------------|
| | | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь |
| 1 | Барилга, байгууламж | 71,326.56 | 9.33% | 70,247.92 | 9.07% | -1,078.64 | -1.51% |
| 2 | Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл | 649,910.14 | 84.97% | 660,757.18 | 85.27% | 10,847.04 | 1.67% |
| 3 | Тавилга, эд хогшил | 1,242.05 | 0.16% | 1,414.00 | 0.18% | 171.94 | 13.84% |
| 4 | Компьютер, техник хэрэгслүүд | 1,876.24 | 0.25% | 1,901.03 | 0.25% | 24.79 | 1.32% |
| 5 | Биет бус хөрөнгө | 40,481.07 | 5.29% | 40,595.89 | 5.24% | 114.82 | 0.28% |
| Нийт хөрөнгө | | 764,836.06 | 100% | 774,916.02 | 100% | 10,079.96 | 1.32% |
| Хуримтлагдсан элэгдэл | | 529,194.27 | 69.19% | 545,851.53 | 70.44% | 16,657.26 | 3.15% |
| Үлдэгдэл өртөг | | 235,641.80 | 30.81% | 229,064.49 | 29.56% | -6,577.31 | -2.79% |

Үндсэн хөрөнгийн дансны үнэ оны эхнээс 6,577.3 сая төгрөгөөр нэмэгдэж 229,064.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй боллоо.

2019 онд хийгдсэн үндсэн хөрөнгийн өөрчлөлтийг үзүүлбэл:

/сая төгрөгөөр/

| Гүйлгээний утга | Анхны үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|-------------------------------|-------------------|-----------------------|-------------------|
| 2019-01-01-ний үлдэгдэл | 764,836.06 | 529,194.27 | 235,641.80 |
| Хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн | 1,135.31 | - | |

| | | | | |
|---|--|-------------------|-------------------|-------------------|
| + | Их засвар, ТЗБАХ-ний ажлаар капиталжуулсан | 13,262.29 | - | |
| | Акталж, данснаас хассан | 4,317.64 | 4,317.64 | |
| - | 2019 оны элэгдлийн зардал | - | 20,974.91 | |
| | 2019-12-31-ний үлдэгдэл | 774,916.02 | 545,851.53 | 229,064.49 |


2019 онд дараах Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол болон албан бичгээр 4,317.6 сая төгрөгийн анхны үнэтэй үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан.Үүнд:

- ✦ 2019 оны 7-р сарын 22-ны өдрийн №289 тоот тогтоолоор 2018 оны үндсэн хөрөнгийн тооллогоор актлах саналтай “ДЦС-3” ТӨХК-ийн балансад бүртгэлтэй цаашид ашиглах боломжгүй болсон 79 нэр төрлийн 4,105.7 сая төгрөгийн анхны үнэтэй, үлдэгдэл өртөггүй тоног төхөөрөмж,
- ✦ 2019 оны 07-р сарын 22-ны өдрийн №294 тоот тогтоолоор 4 нэр төрлийн 149.3 сая төгрөгийн анхны үнэтэй, үлдэгдэл өртөггүй автомашин, механизм,
- ✦ 2019 оны 07-р сарын 23-ны өдрийн А-2/2529 тоот албан бичгээр 102 нэр төрлийн 62.6 сая төгрөгийн анхны үнэтэй, үлдэгдэл өртөггүй тавилга эд хогшил, компьютер хэрэгслүүд,
- ✦ 2019 оны 07-р сарын 22-ний өдрийн №294 тоот тогтоолоор элэгдлээрээ өртгөө нөхсөн 149.3 сая төгрөгийн анхны үнэтэй автомашин, механизмыг дуудлага худалдаагаар 27.8 сая төгрөгөөр худалдан борлуулсан.

III . ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ ХӨГЖИЛ

1.Хүний нөөцийн төлөвлөлт бүрдүүлэлт

Компани 2019 онд нийт 996 ИТА, ажилтны орон тоотойгоор дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулсан.



Компани бүтэц бүрэлдэхүүн, орон тоог оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх хүрээнд сүүлийн 2 жил орон тоо нэмэлгүй тогтвортой барьж ажиллаж байна. Зарим шаардлагатай орон тоог дотооддоо зохион байгуулалт хийж нэмж ажилласан. Албан тушаалын тодорхойлолтын загварыг шинэчлэн мөрдөж ажиллаж байна. Шинэ загварын дагуу бүх ажлын байранд тавигдах шаардлага шинэчлэгдэж байна. Албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан ажил горилогчийг ажилд авч байна.

Жилд дунджаар 140 гаруй ажил горилогчийн анкет материалыг нээлттэй хүлээн авч бүртгэж ажилладаг. Ажил горилогчдын 30 гаруй хувь нь ажилд ордог.

Нийт ажиллах хүчний 82,7% нь цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэх, 2,1% нь түгээх хангах, 14,8% нь бусад чиглэлийн үйл ажиллагаад оролцдог.

2020 оны ИТА-ны нөөцийн судалгаагаар нөөцийг төлөвлөж ажиллахаар төлөвлөөд байна.

Компанийн нийт ажилтны 24 хувь нь эмэгтэй, 76 хувь нь эрэгтэй байна. Ажиллах хүчний бүтцийг хүйсээр ялган харуулбал:

| Ажиллах хүчний бүтэц | Эрэгтэй | Эмэгтэй | Нийт |
|----------------------|------------|------------|------------|
| <i>Удирдлага</i> | 24 | 4 | 28 |
| <i>ИТА</i> | 131 | 58 | 189 |
| <i>Ажилтан</i> | 598 | 181 | 779 |
| Нийт | 753 | 243 | 996 |

Ажиллагчдын насны ангилал:

| | |
|----------------------|-----|
| <i>18-25 нас</i> | 53 |
| <i>26-35 нас</i> | 313 |
| <i>36-49 нас</i> | 430 |
| <i>50-с дээш нас</i> | 200 |

Нийт ажиллагчдын 51,5 хувь нь дээд, 15,5 хувь нь тусгай дунд, 32,9 хувь нь бүрэн болон бүрэн бус дунд боловсролтой байна.

| Төрөл | Ангилал | Ажиллагчдын тоо |
|------------------|--------------------|-----------------|
| <i>Боловсрол</i> | <i>Дээд</i> | 513 |
| | <i>Тусгай дунд</i> | 155 |
| | <i>Бүрэн дунд</i> | 323 |

| | | |
|-------------------------|---------------------------------|-----|
| | <i>Бүрэн бус дунд</i> | 5 |
| <i>Мэргэжил</i> | <i>Дулааны инженер</i> | 223 |
| | <i>Цахилгааны инженер</i> | 130 |
| | <i>Банк санхүү, эдийн засаг</i> | 70 |
| | <i>Бусад</i> | 90 |
| <i>Мэргэжлийн зэрэг</i> | <i>Бакалавр</i> | 513 |
| | <i>Магистр</i> | 41 |
| <i>Мэргэшил</i> | <i>Зөвлөх инженер</i> | 21 |
| | <i>Мэргэшсэн инженер</i> | 37 |
| | <i>Мэргэшсэн төсөвчин</i> | 2 |
| | <i>Мэргэшсэн нябо</i> | 6 |

Ажиллагчдын ажилласан жилийг ангилан харуулбал:

| | |
|----------------------|-----|
| <i>0-5 жил</i> | 226 |
| <i>6-10 жил</i> | 161 |
| <i>11-15 жил</i> | 220 |
| <i>16-20 жил</i> | 140 |
| <i>21-с дээш жил</i> | 249 |

Компанид нийт 318 ИТА, ажилтны албан тушаал байгааг хөдөлмөрийн нөхцлөөр ялган харуулбал:

| Хөдөлмөрийн нөхцөл | Албан тушаалын тоо |
|---------------------------|---------------------------|
| <i>Хэвийн</i> | 88 |
| <i>Хүнд</i> | 215 |
| <i>Халуун</i> | 12 |
| <i>Хортой</i> | 3 |

2019 онд ажлаас гарсан, ажилд шинээр орсон хүмүүсийг боловсролоор харуулбал:

| Боловсрол | Ажилд шинээр орсон | Ажлаас гарсан |
|-----------------------|---------------------------|----------------------|
| Дээд | 67 | 39 |
| Тусгай дунд | 5 | 20 |
| Бүрэн дунд | 22 | 19 |
| Бүрэн бус дунд | 2 | - |
| Нийт | 96 | 78 |

Ажил албан тушаал өөрчлөгдсөн 94 ажилтан байна. Үүнээс албан тушаал буурсан 19, албан тушаал дэвшсэн 6 ажилтан тус тус байна.

Ажлаас гарсан шалтгаанаар харуулбал:

| | |
|--------------------------------|----|
| Өөрийн хүсэлтээр | 20 |
| Өндөр насны тэтгэвэрт гарахаар | 34 |
| Сахилгын зөрчлөөр | 4 |
| Нас барсан | 1 |
| Ажил олгоогчийн санаачилгаар | 8 |
| Хүүхэд асрах чөлөө авсан | 11 |

Хүний нөөцийн бодлогын баримт бичиг:

“Төрөөс Эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг 2015-2030 он” батлагдан гарсантай холбоотойгоор “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019-2024 онд баримтлах хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөн ажиллаж байна.

Хүний нөөцийн бодлогын баримт бичиг нь бүтцийн хувьд:

1. Нийтлэг үндэслэл,
2. Байгууллагын эрхэм зорилго, хэтийн зорилго
3. Хүний нөөцийн удирдлагын хэтийн болон ойрын зорилго
4. Баримтлах зарчим,
5. Зорилт
6. Хүрэх үр гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Бодлогын баримт бичгийн зорилтыг хангах 4 үндсэн чиглэл:

- Хүний нөөцийн төлөвлөлт бүрдүүлэлт
- Сургалт хөгжил, карьер хөгжил
- Нийгмийн асуудал шийдвэрлэлт
- Мэдээлэл технологийн хэрэглээ

Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн 4 зорилтын хүрээнд ажилтныг сонгож авах, сургаж дадлагажуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлууд тус тусын төлөвлөгөөний дагуу хийгдсэн. Төлөвлөгөөний биелэлт 99,6%.

2020 онд бодлогын баримт бичгийг хэмжих үзүүлэлттэй болгож гүйцэтгэлийг дүгнэж ажиллахаар судалгаа хийгдэж байна.

Шинэчлэгдсэн бусад ажил:

Төрийн албаны зөвлөлийн 2019.01.11-ний өдрийн №03 тогтоолоор баталсан Албан тушаалын тодорхойлолтын маягаас үлгэрлэн “ДЦС-3” ТӨХК-ийн алба, хэлтэс, цех, хэсгийн албан тушаалын тодорхойлолтын загварыг гүйцэтгэх захирлын 2019.08.28-ны өдрийн А/293 тоот тушаалаар батлуулсан. Уг загвар нь:

-Ерөнхий мэдээлэл

-Албан тушаалын зорилго, чиг үүрэг
 -Албан тушаалд тавигдах шаардлага
 -Албан тушаалын харилцах субъект
 -Баталгаажуулалт гэсэн 5 хэсгээс бүрдэх бөгөөд албан тушаалд тавигдах шаардлага хэсэгт бичигдэх ажилтны ур чадварыг судалгаан дээр үндэслэн дотоод ба гадаад ур чадвар болгон ангилсан.

Компанийн хөдөлмөрийн дотоод журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд зарим заалтуудыг нэмж оруулах шаардлага үүссэн. Гэрээний загварыг шинэчлэн Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулан мөрдөж ажиллаж байна.

Шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн гэрээнд ажил олгогч болон ажилтны эрх үүргийг тус тусад нь нарийн зааглан оруулсан. Мөн Хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах 7 үндэслэл, хөдөлмөрийн сахилгын 7 ноцтой зөрчлийг тодорхой тусгасан.

2. Сургалтын үйл ажиллагааны ерөнхий үзүүлэлтүүд:

Тайлант хугацаанд сургалтын үйл ажиллагааны статистик үзүүлэлтүүдээс эрс өөрчлөлттэй үзүүлэлт нь:

Сургалтанд хамрагдсан ажилтны тоо давхардсан дүнгээр 67% нэмэгдсэн.

- 1) Сургалтын зардлын гүйцэтгэл өмнөх оноос 27% нэмэгдсэн.
- 2) Нэгж ажилтанд оногдох сургалтын дундаж цаг 31% буурсан.

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Хэмжих нэгж | 2019 он | 2018 он | 2017 он |
|-----|---|------------------------------------|---------------|---------------|---------------|
| 1. | Сургалтын төлөвлөгөө | тоо | 66 | 62 | 61 |
| 2. | Төлөвлөгөөний гүйцэтгэл | | 61 | 58 | 56 |
| 3. | Төлөвлөгөөний биелэлт | % | 92.4% | 93.6% | 92.0% |
| 4. | Нэг ажилтанд ноогдох сургалтын зардал | Мян.төг/хүн | 29.6 | 50.6 | 64.3 |
| 5. | Сургалтын зардал | Төлөвлөгөө | 132.2 | 135.1 | 192.6 |
| 6. | | Гүйцэтгэл | 158.9 | 124.2 | 140.5 |
| 7. | Сургалтанд хамрагдсан ажилтан /албан тушаалаар/ | Нийт | 4464 | 2672 | 2994 |
| 8. | | Удирдлага | 127 | 91 | 92 |
| 9. | | ИТА | 890 | 870 | 669 |
| 10. | | Ажилчид | 3447 | 1711 | 2233 |
| 11. | Сургалт зохион байгуулагдсан байршил | Гадаад орны сургалтын байгууллагад | 21 | 16 | 21 |
| 12. | | Гаднын сургалтын байгууллагад | 188 | 192 | 339 |
| 13. | | Байгууллага дээр | 4255 95.3% | 2464 92.2% | 2634 88% |
| 14. | | Байгууллага дээрх лекц | 2815 66.2% | 1669 67.7% | 1128 42.8% |
| 15. | Нэг ажилтанд ноогдох сургалтын дундаж цаг | Нийт | 6.2 | 8.4 | 8.5 |
| 16. | | Удирдлага | 11.9 | 14.3 | 12.8 |
| 17. | | ИТА | 10.9 | 10.3 | 11.2 |
| 18. | | Ажилчид | 5 | 7.1 | 7.5 |

Эерэг үзүүлэлтүүд:

- ✓ Байгууллага дээр зохион байгуулсан сургалтын тоо, болон лекцийн тоо нэмэгдсэнээр сургалтанд хамрагдсан ажилтны тоо ихсэж 1 хүнд оногдох сургалтын зардал багассан.
- ✓ Удирдлага ИТА нарын сургалтанд хамрагдсан тоо нэмэгдсэн.
- ✓ Сургалтын зардал өмнө оноос нэмэгдсэн.

Буурсан үзүүлэлтүүд:

- Нэгж ажилтанд оногдох сургалтын дундаж цаг буурсан.

Хэсэг нэгжүүдийн сургалтанд хамрагдсан байдал-байршил:

| № | Хэсэг нэгж | Сургалтанд хамрагдсан ажилтны тоо | | | | Орон тоо | Орон тоотой харьцуулахад |
|----------------|------------------------|-----------------------------------|-------------------------------|------------------|-------|----------|--------------------------|
| | | Гадаад оронд | Гаднын сургалтын байгууллагад | Байгууллага дээр | Нийт | | |
| 1 | ТД цех | 2 | 12 | 297 | 311 | 125 | 2.5 |
| 2 | ДДЗ цех | | 8 | 194 | 202 | 58 | 3.5 |
| 3 | ӨДЗ цех | | 8 | 342 | 350 | 90 | 3.9 |
| 4 | ДДТ цех | | 7 | 199 | 206 | 48 | 4.3 |
| 5 | ӨДТ цех | | 7 | 270 | 277 | 68 | 4.1 |
| 6 | Цахилгаан цех | 2 | 18 | 512 | 532 | 106 | 5.0 |
| 7 | ДХХА цех | 3 | 21 | 317 | 341 | 57 | 6.0 |
| 8 | Хими цех | | 8 | 130 | 138 | 35 | 3.9 |
| 9 | Засварын цех | 2 | 31 | 854 | 887 | 179 | 5.0 |
| 10 | Механик цех | | 2 | 357 | 359 | 58 | 6.2 |
| 11 | Уурын хэсэг | | 1 | 97 | 98 | 15 | 6.5 |
| 12 | ҮА | | 5 | 43 | 48 | 13 | 3.7 |
| 13 | ЗХА | 1 | 3 | 62 | 66 | 15 | 4.4 |
| 14 | ЗХНА | 4 | 12 | 68 | 84 | 11 | 7.6 |
| 15 | ТБХ | 2 | 10 | 37 | 49 | 8 | 6.1 |
| 16 | ГТХ | 3 | 3 | 34 | 40 | 5 | 8.0 |
| 17 | ТХХ | 2 | 10 | 51 | 63 | 16 | 3.9 |
| 18 | ТЭЗХ | | 4 | 36 | 40 | 8 | 5.0 |
| 19 | СБХ | | 7 | 83 | 90 | 17 | 5.3 |
| 20 | ХХ | | 2 | 41 | 43 | 7 | 6.1 |
| 21 | БХ | | 3 | 42 | 45 | 6 | 7.5 |
| 22 | ҮААХ | | 2 | 104 | 106 | 21 | 5.0 |
| 23 | АААХ | | 1 | 54 | 55 | 22 | 2.5 |
| 24 | Эмнэлгийн хэсэг | | 0 | 10 | 10 | 3 | 3.3 |
| 25 | Удирдлага+дотоод аудит | | 3 | 21 | 24 | 5 | 4.8 |
| 2019 он | | 21 | 188 | 4255 | 4464 | 996 | 4.5 |
| 2018 он | | 16 | 192 | 795 | 1003 | 990 | 2.7 |
| зөрүү | | +5 | -4 | +3460 | +3461 | +6 | +1.8 |

2019 оны хувьд байгууллага дээр зохион байгуулагдсан сургалтанд хамрагдсан ажилтны тоо 4464 хүрсэн нь өндөр үзүүлэлт юм.

Гадаад оронд зохион байгуулагдсан сургалтууд:

Нийт 11 төрлийн сургалтанд 21 ажилтан хамрагдсан.

| | | | |
|-----------------|--|--|----------|
| БНХАУ | SIEMENS 300 PLS төхөөрөмжийн программ хангамж сургалт | 1. Автоматик электроникийн инженер Х.Гончигрэгцэн | ДХХА цех |
| | | 2. Компьютерийн инженер С.Гэрэлт-Од | ДХХА цех |
| | | 3. Компьютерийн системийн сүлжээ, инженер Д.Мягмарцэрэн | ДХХА цех |
| | Эрчим хүчний ухаалаг хэмжих хэрэгслийн үзэсгэлэн-сургалт | 4. Хэмжүүрийн инженер Б. Соёлмаа | ЦЦех |
| | | 5. Мэдээлэл, хэмжилт, хөргөлтийн системийн инженер П.Батцэнгэл | ЦЦех |
| | | 6. Тооцооны техникч О.Тэнгисболд | ГТХ |
| ОХУ | ДЦС-ын нормативын тооцоо эксперт баталгаажуулалт сургалт | 1. Сургалтын инженер Д.Баярмагнай | ЗХНА |
| | Эрчим хүчний хэмнэлт үр ашиг сэдэвт ЭКСПО–д | 2. Судалгаа шинжилгээний инженер Д.Мөнгөнхүү | ТБХ |
| | | 3. Хэмнэлтийн инженер Л.Хүрэл-Эрдэнэ | ТБХ |
| | | 4. Мэдээлэл, хэмжилт, хөргөлтийн системийн инженер П.Батцэнгэл | ЦЦех |
| ХБНГУ | Германы төслийн сургалт | 1. Дулааны хэмжил зүй хэмжүүр, чанарын инженер До.Төмөрбаатар | ТХХ |
| | Туузан дамжлагын хөтлүүрийн ашиглалт сургалт | 2. Цехийн дарга Б.Түвшинсайхан | ТД цех |
| | | 3. Вагон хөмрөгчийн мастер Д.Ганзориг | ТД цех |
| | | 4. Түлшний тоноглолын засварын мастер В.Тогтбаатар | ЗЦех |
| | | 5. Албаны дарга Х.Баярбаатар | ЗХНА |
| БНСУ | Хүний нөөцийн мэргэжилтнүүдийн сургалт | 1. Хүний нөөцийн мэргэжилтэн М.Энхмаа | ЗХНА |
| | Гамшгийн үеийн ажиллагаа, галын аюулгүй байдлын сургалт | 2. Эрүүл ахуйч Т.Ундраа | ТХХ |
| | | 3. Зуухны эргэх механизм, түлшний засварын инженер Ж.Батжаргал | ЗЦех |
| Филлипин | Англи хэлний эрчимжүүлсэн сургалт | 1. Захирлын туслах Д.Цэрэнлхам | ЗХНА |
| | | 2. Хэлтсийн дарга Л.Хангал-Эрдэнэ | ГТХ |

Гаднын сургалтын байгууллагуудад зохион байгуулагдсан сургалтууд:

2019 онд Гаднын сургалтын байгууллагуудад 188 ажилтан сургалтанд хамрагдсан.Үүнд:

Байгууллага дээр зохион байгуулагдсан сургалтууд


2019 онд байгууллага дээр зохион байгуулагдсан сургалтанд давхардсан тоогоор 4255 ажилтан хамрагдсан.

Байгууллага дээрх тогтмол сургалтууд:


| | Шинэ ажилтныг чиглүүлэх сургалт | Ерөнхий чадамжийн сургалт |
|--------------------------|---------------------------------|---------------------------|
| Зохион байгуулагдсан тоо | 14 | 4 |
| Хамрагдсан ажилтны тоо | 66 | 93 |

Тайлант хугацаанд Шинэ ажилтныг чиглүүлэх сургалтыг 14 удаа зохион байгуулж, нийт 66 ажилтан хамрагдсанаас удирдлага 1, инженер техникийн ажилтан 9, ажилчин 56 хамрагдсан.

Шинэ ажилтны сургалт-цехээр




Төгсөгчдийн дундаж үнэлгээ




Ерөнхий чадамжийн сургалт:

Компанийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, хөгжүүлэх, мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх зорилгоор жинхлэх буюу зэрэг ахих шалгалтанд орох ажилтнуудыг ерөнхий чадамжийн сургалтанд хамруулж, 2019 онд энэ сургалтанд зэрэг ахих 63, жинхлэх 30, нийт 93 ажилтан хамрагдсанаас 10 ажилтан жинхэлж, 29 ажилтан зэргээ ахиулсан байна.



Ерөнхий чадамжийн сургалтанд хамрагдсан ажилчдын судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар, цех хэсгээр гаргаж үзвэл:



Давтамжит сургалтууд:

Худалдан авах ажиллагаанд оролцох /АЗ/ эрх олгох сургалт


“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг хэрэгжүүлэх зорилгоор худалдан авах

ажиллагаанд оролцох мэргэшсэн ажилтан бэлтгэх зорилгоор эрхтэй ажилтны эрхийг сунгах, шинээр эрх авах ажилтнуудад Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны АЗ сургалтыг МУИС, Бизнесийн сургуулийн Бизнес консалтинг төвтэй гэрээ байгуулан 2019 оны 01, 11-р сард 2 удаа зохион байгуулж, нийт 57 ажилтан хамрагдаж, 3,9 сая төгрөг зарцуулсан.

Сургалтанд хамрагдсан 57 ажилтан шалгалт өгснөөс 22 ажилтан эхний өгөлтөөр тэнцэж, шалгалтад тэнцээгүй 35 ажилтан өөрийн зардлаар дахин сургалтанд сууж, шалгалт өгч эрхээ авахаар шийдвэрлэсэн.

Сургалтыг өөрийн байгууллага дээр болон сургалтын байгууллагад гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулж цех нэгжийн удирдлага, ИТА нарыг хамруулсан боловч сургалтанд хамрагдсан ажилтнуудын 25-45% нь шалгалтандаа тэнцэж чадаагүй.

АЗ эрхтэй ажилтнуудын судалгаа



2019 онд АЗ эрхийн сургалтанд хамрагдсан ажилтны тоо



Зуух, даралтат савтай харьцаж ажиллах эрхийн сургалт

“ДЦС-3” ТӨХК-ийн Зуух, даралтат сав, шугам хоолойн бүрэн бүтэн байдал, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа хариуцагч, зуухны машинч, даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажиллах эрх шинээр олгох болон давтан сургалтыг Тусгай зөвшөөрөл бүхий “Хэрлэн эрдэс хими” ХХК-тай хамтран 2019 оны 03 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд станц дээр зохион байгуулж, МХЕГ-ын Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч Б.Мөнхсайханыг оролцуулсан комиссоор шалгалт авсан.

Нийт 145 ажилтанд эрх олгож мэргэшлийн үнэмлэх шинээр олгох болон үнэмлэхний сунгалт хийх ажлыг зохион байгуулсан.

Сургалтанд удирдлага 6, ИТА-35, ажилчид 104, нийт 145 ажилтан хамрагдан шалгалт өгч, Уурын ба усан халаалтын зуух, даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажиллах эрх авсан байна.

Байгууллага дээрх сургалтууд:

ЭХЯ-ны давтан шалгалтанд бэлтгэх сургалт, шалгалт Эрчим хүчний яамнаас зохион байгуулсан Мэдлэг, ур чадварын ээлжит бус шалгалтанд “хангалтгүй” дүн үзүүлсэн ажилтнуудаас давтан шалгалт авах ажлыг зохион байгуулж, шалгалтанд бэлтгэх 12 цагийн сургалтыг 2019 оны 2-р сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулж, 2-р сарын 15-ны өдөр шалгалт авч, давтан шалгалт өгсөн 6, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас яамны шалгалт өгөөгүй 3 нийт 9 ажилтнаас шалгалт авч дүнг Эрчим хүчний яаманд хүргүүлсэн.

Гэрээ байгуулан, байгууллага дээр зохион байгуулсан сургалтууд:

Нийт 10 сургалт Сургалт зохион байгуулах болон хамтран ажиллах 10 гэрээний дагуу зохион байгуулагдаж 395 ажилтан хамрагдсан.

| № | Гэрээгээр зохион байгуулсан сургалт | Сургалтанд хамрагдсан ажилтны тоо | Хувь |
|-----|--|-----------------------------------|-------|
| 4. | АЗ | 37 | 7,9% |
| 5. | Даралтат савны аюулгүй ажиллагаа | 153 | 32,8% |
| 6. | Химийн аюулгүй ажиллагаа | 2 | 0,4% |
| 7. | Цах машин, генераторын сэргээлт /тус бүр 2 гэрээ | 46 | 9,9% |
| 8. | Хэмжлийн нэгдмэл байдал | 42 | 9,0% |
| 9. | Хэмжил зүйн дотоод хяналт | 32 | 6,9% |
| 10. | Статистик мэдээлэл боловсруулах | 40 | 8,6% |
| 11. | ISO 9001:2015 шилжих арга зүй | 22 | 4,7% |
| 12. | ISO-9001:2015 дотоод аудитор | 21 | 4,5% |

Компанийн мэргэжлийн шалгалтын комиссын ажиллагаа:

| Ажилтны тоо | 2019 он | 2018 он | 2017 он |
|---------------------------------------|---------|---------|---------|
| Нийт шалгалт өгсөн | 259 | 139 | 92 |
| Албан тушаалд жинхэлсэн | 63 | 61 | 27 |
| Мэргэжлийн зэргээ ахиулсан | 48 | 47 | 23* |
| 1 сар дагалдсаны дараах шалгалт өгсөн | 32 | 31 | 42 |
| Давтан шалгалт өгсөн | 58 | 27 | 28 |

* Зөвхөн Компанийн МШК-т шалгалт өгч жинхэлсэн ажилтны тоо

Сургалтын үнэлгээ, үр дүн:

2019 оны сургалтын үр дүнд:

- 40 ажилчин мэргэжлийн сертификаттай болсон,
- 153 ажилтан албан тушаалын шаардлагын дагуу аюулгүй ажиллагааны эрх авсан,
- 63 ажилчин албан тушаалдаа жинхлэн мэргэжилтэй ажилчин болсон,
- 48 ажилчин мэргэжлийн зэргээ нэмсэн,
- 3 ИТА зөвлөх инженер болсон,
- 5 инженер мэргэшсэн инженер болсон байна.

Сургалтын үр дүнг оноор харьцуулан харуулбал:

| Үзүүлэлт | 2019 он | 2018 он | 2017 он | 2016 он |
|--|------------|---------|---------|---------|
| Мэргэжлийн сертификаттай болсон ажилчдын тоо | 40 | 19 | 21,0 | 44,0 |
| Эрх авагдсан ажилчдын тоо | 153 | 172 | 207,0 | 86,0 |

Шалгалтын үнэлгээнүүд:

| Үзүүлэлт | 2019 он | 2018 он | 2017 он | 2016 он |
|---|--------------|---------|---------|---------|
| Шинэ ажилтны сургалтын дараах үнэлгээ | 78,2 | 76 | 77,0 | 75,4 |
| Жинхлэх шалгалтын үнэлгээ | 82 | 73,4 | 72,0 | 74,0 |
| Зэрэг ахих шалгалтын үнэлгээ | 84 | 74 | 74,0 | 74,0 |
| ААД мэдлэгийн үнэлгээ-Олимпиад 1-ийн даваа | 64,7 | 63,5 | 62,8 | 50,2 |
| ИТА нарын дүрмийн мэдлэгийн үнэлгээ | 73,81 | 71,9 | 90,0 | |
| Аваарь эсэргүүцэх дасгалын үнэлгээ | | 78,3 | 76,0 | |
| Симуляторын шалгалтын үнэлгээ | 86 | 86 | 86,0 | 72,0 |
| 3-аас дээш Англи хэлний мэдлэгийн түвшинтэй ажилтны тоо | | 49 | 39 | |

Засварын ажилчдын түвшин тогтоох шалгалт:

2019 онд анх удаа чадамж үнэлэх хэлбэрээр засварчдын ур чадварын шалгалтыг авсан. Дулаан механикийн засварчид:

- эргэх механизм,

- хаалт арматур,
- дулаалга гэсэн 3 хүрээнд өндөр зэрэгтэй бага зэрэгтэй гэж хуваагдан шалгалтын даалгавар боловсруулагдсан.

| № | Цех | Шалгалт өгсөн ажилтны тоо | ДҮН | | | | ДУНДАЖ ДҮН | | |
|-------------|---------------|---------------------------|-----------|-----------|-----------|-----------|------------|-------------|-------------|
| | | | Онц | Сайн | Дунд | Муу | 2019 он | 2016 он | Зөрүү |
| 1 | ТД цех | 13 | 1 | 2 | 5 | 5 | 2.9 | 4.13 | -1.2 |
| 2 | ӨДТ цех | 6 | 1 | 2 | 3 | | 3.7 | 4.4 | -0.7 |
| 3 | ЦЦех | 45 | 3 | 15 | 26 | 1 | 3.4 | 3.8 | -0.4 |
| 4 | ДХХА цех | 21 | 4 | 11 | 6 | | 3.9 | 4.1 | -0.2 |
| 5 | ЗЦех | 120 | 26 | 46 | 34 | 14 | 3.7 | 3.91 | -0.2 |
| 6 | МЦех /монтёр/ | 3 | | | 2 | 1 | 2.7 | 3.2 | -0.5 |
| 7 | Уурын хэсэг | 9 | 9 | | | | 5.0 | 3.9 | 1.1 |
| Нийт | | 217 | 44 | 76 | 76 | 21 | 3.7 | 3.92 | -0.3 |

Аюулгүй ажиллагааны дүрмийн зургаадугаар олимпиад

Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтын чанарыг сайжруулах, ажилчдын аюулгүй ажиллагааны мэдлэгийн түвшин, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургагч багш нарын багшлах ур чадварыг дээшлүүлэх, оролцогчдын хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор ААД-ийн мэдлэгийн **Зургаадугаар олимпиадыг** зохион байгуулсан. Олимпиадын:

- 1-ийн даваанд 623 ажилтан оролцсон,
- 2-ын даваанд 177 ажилтан,
- 3-ын даваанд 20 ажилтан шалгарч оролсон.

Олимпиадын нэгийн даваанд оролцвол зохих ажилтнаас 99,4% буюу 623 ажилчин хамрагдсан.

Олимпиадын

- **нэгийн** давааны “Тэргүүн” байранд: **ДХХА цех,**
- **гурвын** давааны “Тэргүүн” байранд **ӨДЗ** цехийн Зуухны машинч **Б.Хандармаа,**
- “**Дэд**” байранд **ДДЗ** цехийн Зуухны машинч **Б.Билгүүн,**
- “**Гутгаар**” байранд Цахилгаан цехийн Электроник, мэдээлэл, хэмжилт, хөргөлтийн монтёр **Л.Энхболор** нар шалгарсан.

Олимпиадын хүрээнд ХАБ сургалт хариуцсан инженерүүдээс цехийн амжилтаар ЦЦ-ийн ХАБ сургалт хариуцсан инженер Ж.Мөнх-Эрдэнэ “Тэргүүн” байранд шалгарч, мөн шагналт байрын болзол хангасан 17 ажилтныг батламж мөнгөн шагналаар урамшуулсан.

Ажил мэргэжлийн уралдаанууд

Салбарын ажил мэргэжлийн уралдаан

“Улаанбаатарын Дулааны Сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойн нэрэмжит Эрчим хүчний салбарын ажил мэргэжлийн уралдаан 2019 оны 6 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, ажил мэргэжлийн уралдаанд Эрчим хүчний салбарын “ДЦС-3” ТӨХК-ийн “**Хос эрчим**”, “ДЦС-2” ТӨХК-ийн “**Алтангадас**”, “ЭДЦС” ТӨХК-ийн “**Эрдэнэт илч**”, “Амгалан Дулааны станц” ХХК-ийн “**Амгалан**” гэсэн 4 байгууллагын дунд:

- Гагнуурчны ур чадвар
- Краны жолооч, оосорлогч дохиочны ур чадвар
- Засвар усралтын ажилтны ур чадвар
- Ажилтны хууль, дүрэм журмын мэдлэг, мөрдөлт

гэсэн 4 төрлөөр зохион байгуулагдаж, манай компанийн “**Хос эрчим**” баг 3-р байр эзэлж, багийн гишүүн, гагнуурчин Т.Сарантөгс “Шилдэг гагнуурчин”-р шалгарсан.


Монтёруудын ажил мэргэжлийн уралдаан

“ДЦС-3” ТӨХК-ийн Монтёруудын ажил мэргэжлийн уралдаан 2 үе шаттайгаар 2019 оны 9 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, ажил мэргэжлийн уралдаанд Түлш дамжуулах цех, Цахилгаан цех, Механик цехийн цахилгааны монтёруудын холимог багаар 9 гишүүнтэй 6 баг 5 төрлөөр өрсөлдөж, онооны нийлбэр дүнгээр байр эзлүүлэн дүгнэхэд:

- 1-р байрыг С.Бямбадорж ахлагчтай “**Эрчим**” баг эзэлж “ӨРГӨМЖЛӨЛ”, 300 000 төгрөгийн мөнгөн шагналаар,
- 2-р байрыг М.Дагвасүрэн ахлагчтай “**Зевс**” баг эзэлж “ӨРГӨМЖЛӨЛ”, 200 000 төгрөгийн мөнгөн шагналаар,
- 3-р байрыг Л.Энхболор ахлагчтай “V.A.R” баг эзэлж “ӨРГӨМЖЛӨЛ”, 100 000 төгрөгийн мөнгөн шагналаар тус тус шагнагдсан.

Тракторчдын ажил мэргэжлийн уралдаан

Түлш дамжуулах цехийн хүнд механизмын хэсгийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, мэдлэгийг бататгах зорилгоор 2019 оны 10-р сарын 25-ны өдөр “Тракторчдын ажил мэргэжлийн уралдаан”-ыг зохион байгуулж, Хүнд механизмын хэсгийн тракторчин, засварчин нийт **16** ажилчид оролцсон ба 4 хүний бүрэлдэхүүнтэй 4 багийн дунд өвлийн бэлтгэл ажлыг хангах, ажлын байрны соёлыг дээшлүүлэх 1 сарын аян зохион байгуулан тракторчдын ур чадварын тэмцээнийг 4 төрлөөр зохион байгуулж онооны нийлбэр дүнгээр байр эзлүүлэхэд,



Багш шавийн гэрээний хэрэгжилт

Станцад мэргэжлээрээ олон жил үр бүтээлтэй ажилласан дадлага туршлагатай, өндөр ур чадвартай ажилтнуудыг дагалдуулан сургаж, мэргэшүүлэх зорилгоор шинээр ажилд орсон болон ажлын байр өөрчлөгдсөн ажилтнуудтай Багш шавийн гэрээ байгуулж гэрээний бүртгэл судалгааг хөтлөн, дагалдуулан сургах явц, гэрээний биелэлтэнд тогтмол хяналт тавьж ажиллаа.

Тайлант хугацаанд нийт 70 Багш шавийн гэрээ хийснээс 42 гэрээний биелэлт хангагдаж, жинхлэх хугацаа болоогүй 17, хугацаа хэтэрсэн боловч жинхлээгүй 6, дагалдангийн хугацаанд өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан 3, дагалдангийн хугацаанд өөр ажилд шилжсэн 2 байна.

Оюутны үйлдвэрлэлийн дадлагын талаар:

2019 онд 13 байгууллагын 381 оюутан, сурагч, дадлагажигч үүнээс Эрчим хүчний сургуулийн 314 оюутан бусад дотоодын их дээд сургуулийн 37 оюутан, Коллеж, МСҮТ-ийн 3 оюутан, ОХУ-ын их дээд сургуулийн 2 оюутан, ЭХХТ Сургалт үйлдвэрлэлийн төвийн 6 инженер багш, Амгалан ДЦС болон бусад газрын 19 дадлагажигчийг гэрээ болон удирдлагын шийдвэрээр хүлээн авч, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулан багш томилж, үйлдвэрлэлийн болон танилцах дадлагыг хийлгүүлэн дадлагын тайланг хамгаалуулж буцаасан. Дадлага хийх явцад ямар нэгэн зөрчил доголдол гараагүй болно.

3.Ажилтны нийгмийн асуудал шийдвэрлэлт

2019-2020 онд Захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээнд заасан үндэслэлээр компанийн ажилтнууд, өндөр настан, ахмад, МШӨ-ний группийн хүмүүст өргөдөл материалыг нь үндэслэн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж буцалтгүй тусламж, нэг удаагийн тэтгэмж, хөнгөлөлт, дэмжлэг олгож ажилласан.

Ажилтнуудад олгосон тусламж, дэмжлэг, хөнгөлөлт:

2019 онд компанийн дотоод журам, хамтын гэрээнд заасан нийт 11 төрлийн хөнгөлөлт, тэтгэмж, дэмжлэг, тусламжид 1 тэрбум 810 сая 711 мянган төгрөг зарцуулсан. Компанийн нийт ажилтны 70,2% нь буюу 700 ажилтан эдгээр тусламж, тэтгэмж, хөнгөлөлт, дэмжлэгт хамрагдсан байна.

| № | Тусламж, дэмжлэг, хөнгөлөлт | Хамрагдсан ажилтны тоо | Зарцуулсан мөнгө /сая.төг/ |
|----|---|------------------------|----------------------------|
| 1. | Халаалтын хөнгөлөлт | 372 | 37,2 |
| 2. | Сувиллын хөнгөлөлт | 192 | 20,4 |
| 3. | Өндөр насны тэтгэврийн тэтгэмж | 36 | 1,120 |
| 4. | Хүүхэд асрах чөлөөтэй эхийн тэтгэмж | 27 | 7,6 |
| 5. | МШӨ-ний группээс өндөр насны тэтгэвэрт шилжсэнд олгох тэтгэмж | 10 | 87,9 |
| 6. | Орон сууцны дэмжлэг | 13 | 200,1 |
| 7. | Уй гашуу тохиолдсон ажилтанд олгох буцалтгүй тусламж | 25 | 59,5 |
| 8. | Өрх толгойлсон, ам бүл олон, амжиргаа багатай ажилтанд олгох буцалтгүй тусламж | 2 | 2,0 |
| 9. | Эмчилгээний зардлын буцалтгүй тусламж | 9 | 64,9 |

| | | | |
|-----|----------------------------|----|-------|
| 10. | ҮО-ын нөхөн төлбөр | 3 | 199,5 |
| 11. | 50 насны урамшуулал | 11 | 11,1 |

Шагнаж урамшуулсан байдал:

2019 онд нийт 11 төрлийн шагналаар 149 ажилтныг төр засгийн, засгийн газрын болон бусад шагналаар шагнаж урамшуулах ажилд 12,5 сая төгрөг зарцуулсан.

Мөн хамтран ажилладаг 7 байгууллагын 30 ажилтан, албан хаагчийг 3,5 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан байна.

| Төр засгийн одон медаль | Засгийн газрын шагнал | Бусад шагнал |
|---|--|---|
| <i>Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон</i> 3 | <i>Эрчим хүчний тэргүүний ажилтан</i> 7 | <i>Монголын залуучуудын холбооны шагнал</i> 40 |
| <i>Алтангадас одон</i> 13 | <i>Бусад салбарын тэргүүний ажилтан</i> 2 | <i>Эрчим хүч, геологи уул, уурхайн ҮЭХ-ны шагнал</i> 10 |
| <i>Хөдөлмөрийн хүндэт медаль</i> 17 | <i>Эрчим хүчний яамны хүндэт жуух бичих</i> 57 | |

Компанид нийт 443 өндөр настан, ахмад бүртгэлтэйгээс 44 ахмад нь 2019 онд шинээр нэмэгдсэн байна. 2019 онд нас барсан өндөр настан ахмадууд, өрхийн амжиргааны батагаажих доод түвшингээс доогуур орлоготой ахмадуудын ар гэрт 36 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна. Мөн рашаан сувилалд амарч сувилуулсан 90 өндөр настан ахмадад 8,9 сая төгрөгийн сувиллын хөнгөлөлт олгож ажилласан.

Компани өндөр настан, ахмад, группийн хүмүүстээ аливаа хөнгөлөлт, тэтгэмж, тусламжийн мөнгө олгохдоо бэлнээр кассаар өгдөг хүндрэлтэй асуудлыг арилгаж 2019 онд бүх өндөр настан, ахмадуудаа данстай болгох зорилт тавьж ажилласан. 2019 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар зорилт бүрэн хангагдаж 1 ахмад, 6 группийн хүнээс бусад бүх хүн данстай болж дансаар гарын бэлэг, бусад тусламж, хөнгөлөлтийн мөнгөө авч байна.

Мөн жил бүр ахмадын баярыг тохиолдуулан өндөр настан ахмадуудаа, “Үйлдвэрлэлийн ослын улмаас бэртэж гэмтсэн болон амь үрэгдсэн ажилчдын дурсгалыг хүндэтгэх Олон улсын өдөр-04 дүгээр сарын 28”-ны өдөр мэргэжлээс шалтгаалах өвчнөөр группт байдаг хүмүүсээ хүлээн авч хүндэтгэл үзүүлэх ажлыг уламжлал болгон зохион байгуулж ажиллаж байна.



2019 онд төр засгийн одонгоор 10, засгийн газрын шагналаар 17 өндөр настан, ахмадыг шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Компанийн ажилчдын орон сууцны барилгын ажлын явц, хөнгөлөлт:

2015-2016 онуудад компаниас нийт 189 ажилтанд орон сууцны хөнгөлөлт олгох шийдвэр гарч хөнгөлөлтийн 1.546.216.200 төгрөгийг орон сууц барих “Соёмбо констракшн” ХХК-д шилжүүлсэн. Үүн дээр ажилчид хувиасаа 1.164.725.870 тэрбум төгрөг нэмж нийт 2.710.942.070 төгрөгийн “Соёмбо констракшн” ХХК-д шилжээд байна.

Барилгын ажил удааширнаас шалтгаалан 56 ажилтан орохгүй гэсэн хүсэлт гаргаад байна.

Компаниас хөнгөлөлт аваагүй боловч хувиасаа урьдчилгаа төлбөр төлж гэрээ хийсэн 21 ажилтан байна. Нийт орон сууцанд орно гэж мэдэгдсэн 140 ажилтан байна. Үлдсэн ажилтнууд орохгүй, орох эсэх нь тодорхойгүй байдалтай байна.

Орон сууцны барилгыг 16 давхар байсныг 12 болгох шийдвэр гарсан. Барилгын ажлын гүйцэтгэл 70 орчим хувьд хүрээд санхүүжилтгүй зогссон байдалтай байна.

4. Ажлын байрны 5С, бүтээмжийг сайжруулсан талаар:


2019 онд бүтээмж, чанарын баг **98** хүний бүрэлдэнхүүтэйгээр компанийн чанарын менежментийн тогтолцоог сайжруулах, бүтээмж дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

- Сайн саналын баг 12
- Чанарын дугуйлангийн хороо 9
- 5С-ийн баг 18
- ЧУТ ажлын хэсэг 59

Бүтээмж, чанар дээшлүүлэх хөтөлбөрийн үр дүнд баримт бичгийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах, ажилтнуудын ажлын идэвх санаачлага, хандлага, багаар ажиллах чадавхийг нэмэгдүүлэх, ажлын байрны эмх цэгц, ариун цэвэр тохижилтыг сайжруулах, ажилтнуудын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангахад тодорхой хувь нэмрээ оруулаад байна.

5С хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэлийн, оффиссын, ахуйн, нийтийн эзэмшлийн, гадна талбайн зориулалт бүхий 463 ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалт, өнгө үзэмжийг сайжруулах 5С-ийг хэрэгжилтэнд хяналт тавихаар 5С-ийн багийн гишүүд нь 2019 онд 19 хүний бүрэлдэхүүнтэй 6 багт хуваагдан нэг баг нь 2 нэгж, хэсгийг хариуцан ажиллалаа.


5С-ийн хэрэгжилт /түвшин тус бүрээр/:



Сайн саналын систем

Сайн саналын систем хөтөлбөрийн хүрээнд 2019 онд ажилтнуудын кайзен хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор “996 сайн санал, 996 сайн ажил, 996 эерэг дүн” сэдэвт жилийн аян, “Шинэ санаа шударга урамшуулал” сэдэвт нэг сарын болзолт уралдааныг тус тус зарлаж, удирдамжийг гүйцэтгэх захирлын А/169 тушаалаар батлуулж ажилласан. Аяны хүрээнд:

- Нийт ирсэн санал 1058
- Хэрэгжсэн санал 484,
- Хэрэгжих боломжтой санал 579,
- Сайн санал 129,
- Хамрагдсан ажилтны тоо 541



“996 сайн санал, 996 сайн ажил, 996 эерэг дүн” аяны зорилтын биелэлт:

| Зорилтын биелэлт | | Биелэлт /тоо/ | Биелэлт /хувь/ |
|------------------------|------------------------|---------------|----------------|
| Нийт ирсэн саналын тоо | | 1058 | 106% |
| Үүнээс: | Хэрэгжсэн | 484 | 45% |
| | Хэрэгжээгүй | 579 | 55% |
| | Сайн саналын тоо | 129 | 12% |
| | Хамрагдсан ажилтны тоо | 541 | 54% |

Чанарын дугуйлан хөтөлбөр /ЧД/

2019 онд Компанийн хэмжээнд бүртгэлтэй 15 чанарын дугуйлангаас 6 чанарын дугуйлан тогтмол ажиллаж, ажлын байрны эмх цэгц, ХАБ, тоноглолын найдвартай ажиллагааг хангах чиглэлээр 6 төсөл, 30 ажлыг санаачлан хийж Чанарын дугуйлангийн хороонд тайлагнаж ажилласан. ЧД-уудаас ирсэн нийт 6 төслөөс:

- Хэрэгжсэн 5 төсөл,
- Техникийн зөвлөлөөр дэмжигдсэн 1 төсөл байна.

Чанарын менежментийн тогтолцоо, ISO 9001:2015 стандарт:

- 2019 онд Компанийн чанарын менежментийн тогтолцооны үр нөлөөг тогтворжуулах, ISO 9001:2015 стандартад шилжих, гэрчилгээ авах зорилт дэвшүүлэн ажилласан.
- Зорилтыг хэрэгжүүлж шинэ стандартад шилжихэд нэн тэргүүнд шаардлагатай гол гол баримт бичгүүдийн жагсаалтыг гаргаж алба, хэлтэс, цех, хэсэг тус бүр боловсруулахад компанийн гүйцэтгэх захирлынтушаалаар батлагдсан 59 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг голлох үүрэгтэй ажилласан.

- Ажлын хэсэг болон компанийн нийт ИТА ажилтнуудын идэвхи чармайлтын хүчинд компани ISO 9001:2015 стандартын баталгаажуулалтын 1-р шатны аудитад амжилттай шалгуулсан.

IV. ӨВЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ, ИХ ЗАСВАРЫН ТАЛААР:

2019-2020 оны өвлийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөнд нийт 41 ажил төлөвлөгдсөнөөс 41 ажил бүрэн хийгдэж , гүйцэтгэл – 100 % .

1.Их засвар:

2019 – 2020 оны өвлийн бэлтгэл хангаж 6 үндсэн тоноглолд их засвар, 1 үндсэн тоноглолд дунд засвар, 129 туслах тоноглолд их засвар хийхээр төлөвлөж гүйцэтгэсэн.

Үндсэн тоноглолын их засвар:

2.Туслах тоноглолын их засвар:

Нийт 129 туслах тоноглолд их засвар хийхээс 129 тоноглолын их засвар

| № | Тоноглолын нэр | Төлөвлөсөн хугацаа | | Засварын хугацаа | | Гүйцэтгэл | |
|---|--------------------------------------|--------------------|----------------|------------------|---------|-----------|-------------------------|
| | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа | Эхэлсэн | Дууссан | Хувь | Гүйцэтгэгч |
| 1 | Зуух №11 их засвар | 15/V | 25/IX | 1/V | 5/XI | 100% | Энергосервис монтаж ХХК |
| 2 | Зуух №12 их засвар | 15/V | 1/X | 1/V | 31/X | 100% | СММ ХХК |
| 3 | Зуух №3их засвар | 01/VI | 01/IX | 22/V | 20/IX | 100% | Эрчим дөл ХХК |
| 4 | Зуух №5 их засвар | 01/VI | 01/IX | 27/V | 19/IX | 100% | Мон Илч ХХК |
| 5 | Зуух № 4 нэмэлт халах гадаргуу солих | 01/VII | 01/IX | 17/VI | 12/VIII | 100% | МЭЗ ХХК |
| 6 | Турбингенератор №4 их засвар | 15/VII | 25/IX | 22/VII | 19/IX | 100% | Эрчим маш ХХК |
| 7 | Турбингенератор №7 их засвар | 01/VIII | 15/X | 15/VIII | 5/XI | 100% | Гкал ХХК |

бүрэн хийгдэж дууссан байна.

V.ТЗБАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙСЭН АЖИЛ :

1. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэл

Нийт 46 ажил төлөвлөснөөс 45 ажил бүрэн хийгдэж, 1 ажил эхэлсэн үргэлжилж байна. Гүйцэтгэл – 98.3%

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төлөвлөсөн хөрөнгө /сая.төг/ | Гүйцэтгэл |
|---|-------------------------|------------------------------|-----------|
|---|-------------------------|------------------------------|-----------|

| | | | |
|---|--|------|--|
| 1 | ӨДХ-ийн 110кВ-ын цэнэг шавхагчийг ОПН болгох | 60.0 | 3 удаа тендер зарлагдаад амжилтгүй болсон. 12 дугаар сард шууд гэрээ байгуулсан. |
|---|--|------|--|

2. ТЗБАХ-аар хийгдсэн ажлын гүйцэтгэл

Нийт 24 ажил төлөвлөснөөс 23 ажил бүрэн хийгдэж, 1 ажил эхэлсэн үргэлжилж байна. Гүйцэтгэл - 98.3%

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төлөвлөсөн хөрөнгө /сая.төг/ | Гүйцэтгэл |
|---|--|------------------------------|---|
| 1 | ОРУ-110 хуурай салгууруудыг шинэчлэх сольж | 85.08 | Бараа материал нийлүүлсэн. Гэрээ сунгагдсан. Хавар их ачаалал өнгөрөхөөр хийгдэнэ |

ТЕХНИКИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ :

“ДЦС-3 ТӨХК-ийн 2032 он хүртэл баримтлах техникийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Техникийн бодлогынхоо хүрээнд хийж хэрэгжүүлэх техник технологийн шинэчлэл, төсөл хөтөлбөрүүдийн судалгаа тооцоог хийж ЭХЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан.

Энэ бодлого шийдвэрийн дагуу 2019 онд:

- *Насос станцын тосон таслуурыг вакуум таслуураар шинэчилсэн.*
- *Зуух №9-н Утаа сорогч, үлээх салхилуурыг инвертерийн системд шилжүүлсэн.*
- *Үнсэн сангийн шинэчлэлийн зураг, төсөв хийлгэж, шинэ үнсэн сан барих ажлыг эхлүүлсэн.*
- *ДДС-ын суурин 250 МВт-ын шинэ станц барих төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан*
- *ӨДС-ийн хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж ЭХЯ-ний ШУТЗ-ааер хэлэлцүүлэн батлуулсан гэх мэт ажлууд хийж, хэрэгжүүлсэн.*

Станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх төсөл:

Станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх төслийн хүрээнд ОХУ-ын Интер РАО экспорт компанийн мэргэжилтнүүдтэй 2 удаа уулзалтыг зохион байгуулж төслийн ажлын даалгаварын хүрээнд ТЭЗҮ-ийн техникийн болон хэрэгжүүлэх хугацааг тохирч протокол хөтлөн ажилласан. Гэрээний хэлцэл хийгдэж байна. Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж, БОАЖЯ-ны мэдээллийн нэгдсэн санд оруулсан.



Өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх төсөл:

“Дулааны III цахилгаан станц” ТӨХК-ийн өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 309 дугаар тогтоол гарсан. Үүнтэй холбогдуулан төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан станцын техникийн зөвлөл болон ЭХЯ-ны ШУТЗ-д танилцуулж холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан. Мөн төслийн санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хүрээнд зээлийн материал бүрдүүлж Хөгжлийн банканд зээлийн хүсэлт гаргасан.




Шинэ үнсэн барих:

Шинэ үнсэн барих ажлын зураг төсөв хийлгэж, Үнсэн сан барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажил нь эхэлсэн

БКЗ-100-220/4С зуухыг “Нам температурын хурдасгасан буцламтгай үет шаталт”-ын \ХБУШ\ технологид шилжүүлэх техникийн шийдэл :

Техникийн бодлогын хүрээнд Өндөр даралтын хэсгийн БКЗ-220-100 маркийн зуухны шаталтын технологийг “Нам температурын хурдасгасан буцламтгай үет шаталт”-ын \ХБУШ\ технологид шилжүүлэх техникийн шийдэл, ТЭЗҮ-ийг боловсруулан станцын техникийн зөвлөл болон ЭХЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан. 2020 онд зураг төсөлийн ажлыг хийхээр хөрөнгө төлөвлөн ажиллаж байна.



3. Үйлдвэрлэлийн экологи, байгаль орчны хяналтын талаар :

Нүүрсний зарцуулалт:

Станц нь 2019 оны гүйцэтгэлээр 1,305,344 тн багануурын нүүрс, 15264 солярка, 897 тн мазут түлсэн нүүрсний үнслэг гүйцэтгэлээр 8.39 %-тай гарсан нь үнс хадгалах санд 109,518 тн үнс хаягдсан тооцоо гарсан. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нүүрс хадгалах ил талбай болон үнс хадгалах сангаас салхи ихтэй өдрүүдэд жижиг хэмжээний тоосонцор ойр орчмыг бохирдуулах эрсдэл өндөр гарсан тул нүүрс хадгалах ил талбайгаас тоосролт босгохгүй байх талаар анхаарч ажилласан.

Техникийн усны зарцуулалт:

Станц нь тухайн жилийн ус ашиглуулах дүгнэлтийг “Монгол Ус” ТӨААТГ-аар гаргуулж “Туул голын сав газар”-тай ус ашиглах гэрээ байгуулж, станцын 2019 оны техникийн усны зарцуулалт гүйцэтгэлээр 7,448,845 тн өмнөх оны мөн үеэс 40.3 мян.тн усыг хэмнэн ажилласан.

Үнс хадгалах сан:

Одоо ашиглаж байгаа Үнсэн сан №5 нь 2010 оны 03 сарын 18-ны өдөр ашиглалтанд орсон, 2020 оны 10 дугаар сард дүүрэх тооцоо гарсан. Үнсэн сан шинээр барих ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлэн графикийн дагуу ажиллаж байна.

Зуухны үнс баригч болон үнс хадгалах сангаас 2019 онд улирал тус бүрийн үнсний дээж авч МХЕГ-ын итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээнд хамруулж хяналт тавин ажилласан.

Агаар бохирдуулах хорт бодисын хяналт:

Станцын яндангаар хаягдаж байгаа хорт бодисын хэмжээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа MNS 5919:2008 стандартаас хэтрээгүй.

2019 оны нүүрсний зарцуулалтаас БОАЖЯамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/600 тоот тушаалаар баталсан аргачлалын дагуу агаар бохирдуулах бодисыг / SO₂, NO_x, CO, Pm / тооцож Монгол улсын засгийн газрын 2011 оны 92 дугаар тоот тогтоолын дагуу бодис тус бүрийн мөнгөн дүнгээр нийт 43 сая төгрөгийн төлбөрийг төлсөн.

Дунд даралтын станц:

| Дунд даралтын станцын яндангаар хаягдах утааны хийн хэмжилт - 2019 он | | | | | | | | | | |
|---|--|-----------------------------------|--|-----------------|--------|-------------|--|--------------------------------------|---------------------------------------|--|
| Эх үүсвэрийн нэр, байршил | Хэмжилтийн цэг зуухны хүчин чадал | Хэмжилт хийсэн он, сар, өдөр, цаг | Бохирдуулах бодисын ялгарлын хэмжээ, мг/м3 | | | | Хаягдал утаа цэвэрлэх, шүүх төхөөрөмж, АҮК | Хаягдал утааны хийн хурд, температур | Хэмжилтийн арга аргачлал, багажны нэр | |
| | | | SO _x | NO _x | CO | TPS | | | | |
| ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРОО "ДЦС-3" ТӨХК | ДУНД ДАРАЛТЫН ХЭСГИЙН БКЗ-75-39 МАЯГИЙН ЗУУХ | 2019.01 Сар | 1287 | 870 | 3995 | | 90-92% | 2-3 м/с, 75°c | ТЕСТО-350 XL | |
| | | 2019.02 Сар | 1501.6 | 1308.8 | 3889 | | 90-92% | 2-3 м/с, 75°c | ТЕСТО-350 XL | |
| | | 2019.03 Сар | 1441.1 | 972.6 | 3450 | | 90-92% | 2-3 м/с, 75°c | ТЕСТО-350 XL | |
| | | 2019.04 Сар | 1857 | 1315 | 3419 | | 90-92% | 2-3 м/с, 76.5 °c | ТЕСТО-350 XL | |
| | | 2019.05 Сар | 1394 | 1010 | 3685 | | 90-92% | 2-3 м/с, 77.3 °c | ТЕСТО-350 XL | |
| | | БҮРЭН ЗОГСОЛТ | | | | | | | | |
| | | 2019.09 Сар | 1282.5 | 1072.5 | 2800 | | 90-92% | 2-3 м/с, 82.3 °c | ТЕСТО-350 XL | |
| | | 2019.10 Сар | 1362 | 958.6 | 3569 | | 90-92% | 2-3 м/с, 82.3 °c | ТЕСТО-350 XL | |
| | | 2019.11 Сар | 1514 | 956 | 3412 | | 90-92% | 2-3 м/с, 82.3 °c | ТЕСТО-350 XL | |
| | | 2019.12 Сар | 1213 | 724 | 3245 | | 90-92% | 2-3 м/с, 82.3 °c | ТЕСТО-350 XL | |
| | Хэмжилт | Дундаж | 1415.6 | 986.6 | 3496.0 | | | | | |
| | MNS:5919:2008 | Стандарт | 1931 | 1270 | 3550 | 21000 mg/m3 | | | | |

Өндөр даралтын станц:

| Name£° | Boiler CEMS Months Data Report | | | | MNS:5919:2008 standart | | | |
|----------|--------------------------------|----------|------------|----------|------------------------|----------|-----------|----------|
| Number£° | Dust | | SO2 | | Nox | | CO | |
| | Measured | Measured | Measured | Measured | Measured | Measured | Measured | Measured |
| | mg/m3 | mg/m3 | mg/m3 | mg/m3 | mg/m3 | mg/m3 | mg/m3 | mg/m3 |
| 2019-01 | 300 | 153 | 503 | 56 | | | | |
| 2019-02 | 283 | 153 | 502 | 54 | | | | |
| 2019-03 | 300 | 153 | 502 | 53 | | | | |
| 2019-04 | 256 | 158 | 511 | 48 | | | | |
| 2019-05 | 300 | 281 | 837 | 56 | | | | |
| 2019-06 | 298 | 285 | 833 | 55 | | | | |
| 2019-07 | 298 | 286 | 837 | 58 | | | | |
| 2019-08 | 234 | 224 | 660 | 45 | | | | |
| 2019-09 | 299 | 284 | 836 | 55 | | | | |
| 2019-10 | 250 | 245 | 726 | 48 | | | | |
| 2019-11 | 258 | 284 | 970 | 85 | | | | |
| 2019-12 | 282 | 345 | 664 | 93 | | | | |
| | standart | standart | standart | standart | standart | standart | standart | standart |
| average | 10800 mg/m3 | 280 | 1485 mg/m3 | 238 | 1100 mg/m3 | 698 | 300 mg/m3 | 59 |

Станцын үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлын талаар:

Станцын үйл ажиллагаанаас ялгарсан хог хаягдлыг хуулийн дагуу Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тай гэрээ хийн 2503 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт том ачааны машинаар 188 удаа, жижиг ачааны машинаар 202 удаа зөөж 17.3 сая төгрөг зарцуулсан байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, аудитын дүгнэлт, зөвлөмж тухай:

1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй “Экологийн бүтээмж” ХХК-аар нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэж Байгаль орчин аялал жуулчлалын яамны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Үүнд:

ДЦС-3 ТӨХК-ийн үндсэн үйл ажиллагаа, шинэ үнсэн сан барих, ӨДС-ын 75 МВт-аар өргөтгөх, ДДСтанцын 250 МВт-аар өргөтгөх төсөл

2. Байгаль орчны аудитын ажлыг байгаль орчны аудит хийх гэрээ байгуулан аудитыг 7 чиглэлээр нийт 122 шалгуур үзүүлэлтээр үнэлэн үзэв.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлт:

Байгаль орчныг хамгаалах талаар үндсэн дөрвөн бүлэг бүхий 25 ажил төлөвлөж 23 ажил бүрэн хийгдэж тайлант хугацаанд хоёр ажил үргэлжлэн хийгдсэн. Компаний нийт алба, хэлтэс, цех, хэсэг, нэгжүүд байгаль орчны асуудлыг үндсэн үйл ажиллагаатай уялдуулж шаардлагатай арга хэмжээг авч идэвхи санаачлагатай ажилласан.

VI. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР :

“ДЦС-3” ТӨХК нь 2019 онд тодотгосон төлөвлөгөөг оруулаад 38,542,891 мянган төгрөгийн нийт 187 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс өнөөдрийн байдлаар 187 худалдан авалтыг ямар нэг байдлаар зохион байгуулаад байна. Огт зохион байгуулагдаагүй худалдан авалт байхгүй байна. Худалдан авах ажиллагааны биелэлт 100 хувьтай байна.

Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагаа байхгүй болно. Хийх зайлшгүй шаардлагатай худалдан авалтуудыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр 2019 оны 8-р сарын 22-ны өдрийн 27-р тогтоолоор худалдан авах ажиллагаанд тодотгол оруулан нэмэлт худалдан авалтуудыг зохион байгуулсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Сангийн яаманд 8 гомдол, ШӨХТГ-т 2 гомдол гарсан. ШӨХТГ-ын “төрөл бүрийн шүүр, арчих материал”, “автомашин” худалдан авах тендер шалгаруулалтын гомдолд техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулан тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэх гэж ирсэн ба шаардлагатай техникийн тодорхойлолтод өөрчлөлтийг оруулан тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн зохион байгуулсан. Сангийн яаманд гарсан 8 гомдлын хувьд: “Үнсэн сан шинээр барих” ажлын тендерт 2 удаа үнэлгээг дахин хийх гэж шийдвэр гарсан ба үнэлгээг дахин хийн хэрхэн шийдвэрлэснээ Сангийн Яаманд танилцуулсан. “Насос, насосны сэлбэг” нийлүүлэх тендерт дахин зарлах гэж шийдвэр гарсан ба тендерийг дахин зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. “Асбестан эдлэл” нийлүүлэх тендерт үнэлгээг дахин хийх гэж шийдвэр гарсан ба үнэлгээг дахин хийн хэрхэн шийдвэрлэснээ Сангийн Яаманд бичгээр мэдэгдсэн. “Мазут”, “Олон цэгийн доргионы кварц хэмжүүр”, “Тээрмийн ган бөмбөлөг”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх” гэсэн худалдан авалтуудад хууль журмын дагуу цааш үргэлжлүүлэх гэсэн шийдвэр гарсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар 466,6 сая төгрөгийн бараа дотоодоос худалдан авахаар гэрээ байгуулан ажилласан байна. “Амно фейшн” ХХК-тай хөдөлмөр хамгааллын хувцас нийлүүлэх, “Баганадант” ХХК-тай хөдөлмөр хамгааллын бээлий худалдан авах, “Як трейд” ХХК-тай хөдөлмөр хамгааллын гутал худалдан авах, “Мэш” ХХК-тай давс худалдан авах, “АПУ дэйри” ХХК-тай нормын сүү худалдан авах, “Глобал ацетилен” ХХК-тай кислород худалдан авах, “Металл индустриал” ХХК-тай Бутлагч М20*20 алх решетка хийх гэрээ байгуулан ажиллалаа. Гэрээний хэрэгжилтийн хувьд ямар нэгэн асуудал зөрчил үүсээгүй хугацаандаа хэрэгжсэн байна.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК 2019 онд тодотгосон тлөвлөгөөг оруулаад нийт 187 худалдан авах ажиллагаа төлөвлөснөөс 157 худалдан авалтыг цахимаар зохион байгуулахаас 155 худалдан авалтыг цахимаар зохион байгуулсан. Нийт 98,7 хувийг цахимаар зохион байгуулсан байна. Цахимаар зохион байгуулаагүй 2 тендер байгаа нь Турбогенератор №4, Турбогенератор №7-ийн их засвар байна. Тухайн 2 тендерийг 2018 оны 12-р сард уламжлалтаар зарласан нь турбогенераторуудын их засварт шаардлагатай сэлбэг материалууд нь үйлдвэрлэхэд дор хаяж 6 сар шаардагддаг тул тухайн ондоо амжиж засварт орж өвлийн бэлтгэл хангах боломжгүй болох эрсдэлтэй байдаг тул сонгон шалгаруулалтыг эрт зохион байгуулсан.

VII. ТЕХНОЛОГИЙН ЗӨРЧИЛ, ХАБЭА-н ТАЛААР :

2019 онд компанийн хэмжээнд аваари, нэг ба хоёрдугаар зэргийн саатал гараагүй ажилласан.

Гэмтэл 35 удаа гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27,0%-аар буурсан байна. Нийт гэмтлийн улмаас 861,2 мян.кВт/ц диспетчерийн графикийн зөрчил авсан. Технологийн зөрчлийн 3 нь хүний буруугаас шалтгаалан гарч, 23,2 мян.кВт/ц диспетчерийн графикийн зөрчил авч, 5455,4 төгрөгийн хохирол тооцогдсон ба 32 нь техникийн шалтгаанаас гарч, 838,0 мян.кВт/ц диспетчерийн графикийн зөрчил авч, 3534,6 мян.төгрөгийн хохирол тооцогдсон. Хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж гарсан 3 удаагийн гэмтэлд 11 ИТА, ажилтан холбогдож, арга хэмжээ тооцогдсон байна.

Цахилгаан хөдөлгүүрийн гэмтлийн хувьд 6кВ-ын хөдөлгүүр 1 удаа, 0,4 кВ-ын хөдөлгүүр 6 удаа гарсан. 6кВ-ын цахилгаан хөдөлгүүрийн гэмтэл өмнөх оноос 50%-иар, 0,4 кВ-ын хөдөлгүүрийн гэмтэл өмнөх оноос 5-аар буюу 50 %-иар тус тус буурсан байна.

| Д/д | Үзүүлэлт | | Хэмжих нэгж | 2018 он | 2019 он | зөрүү | |
|--------------------------------|-----------------|--------------------|-------------|-----------|-----------|------------|---------------|
| | | | | | | тоо | % |
| 1 | Аваари | | тоо | 1 | - | -1 | -100% |
| | Үүнээс | Хүний буруугаас | | | | | |
| | | Техникийн шалтгаан | | | | | |
| | | Гадны байгууллага | | 1 | - | -1 | -100% |
| 2 | Саатал-1 | | тоо | 1 | - | -1 | -100% |
| | Үүнээс | Хүний буруугаас | | | | | |
| | | Техникийн шалтгаан | | | | | |
| | | Гадны байгууллага | | 1 | - | -1 | -100% |
| 3 | Саатал-2 | | тоо | - | - | - | 0% |
| | Үүнээс | Хүний буруугаас | | | | | 0% |
| | | Техникийн шалтгаан | | | | | |
| | | Гадны байгууллага | | | | | |
| 4 | Гэмтэл | | тоо | 46 | 35 | -11 | -24,0% |
| | Үүнээс | Хүний буруугаас | | 6 | 3 | -3 | 0% |
| | | Техникийн шалтгаан | | 34 | 31 | -3 | -8,8% |
| | | Гадны байгууллага | | 6 | 1 | -5 | -83,3% |
| Нийт технологийн зөрчил | | | тоо | 48 | 35 | -13 | -27,0% |

- **ХАБЭА-Н ТАЛААР:**

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг компанийн хэмжээнд жигд хангуулах үүднээс нарядын системийн тусгай үүрэг хүлээгсэдийг Гүйцэтгэх захирлын 2019.03.05-ны өдрийн тушаалаар томилж үүрэг, хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн.

Цехүүдийн ХАБ-ыг хангуулах I, II шатны үзлэгийн чанар гүйцэтгэл, журнал хөтлөлт, зөрчил устгасан байдлыг сард 2 удаа шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулж ажиллав. Мөн ХАБ-ыг хангуулах III шатны үзлэгийг улирал бүр батлагдсан хөтөлбөр, сэдвийн дагуу 4 удаа зохион байгуулж, үзлэгийн дүнгийн хурлын мөрөөр хийгдэх ажлын төлөвлөгөө гарган гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав.

Ажилтан бүрийг аюул илрүүлэх ажилд татан оролцуулснаар энэ онд нийт **4981** ширхэг аюулыг мэдээлэх хуудас бичигдэж, **2793** ширхэг аюулыг хүмүүс өөрсдөө засч хэвийн болгосон.

ХАБЭА-н тухай хуулийн 28.1.4-д заасны дагуу ажлын байранд учирч болох аюул ослыг арилгаж, хяналт тавих зорилгоор эрсдлийн үнэлгээ хийх ажлыг жилийн туршид эрсдлийн багууд хамтран хийж, эрсдлийн үнэлгээнд дүн шинжилгээ дүгнэлт гарган харилцан ярилцаж, туршлага солилцох журмаар зохион байгуулсны үр дүнд нийт **66** ажлын байранд эрсдлийн үнэлгээ хийж, **81** ажлын байрны эрсдлийг бууруулан ажиллав.

Сар бүр хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах талаар тодорхой зорилт тавьж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.

“Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын журам”, “Цахилгаан ба дулааны тоног төхөөрөмжид цоож, пайз тавих, авах журам”-ыг шинэчлэн боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2019 оны 09-р сарын 25-ны өдрийн А/328 тоот тушаалаар батлуулав. Журмуудыг станцын бүх ажилтнуудад танилцуулж, ажлын байруудад тарааж сурталчлан журмын мөрдөлтөнд хяналт тавьж ажиллав.

Компанийн хэмжээнд өгөгдөж байгаа шат, шатны зааварчилгаа өгөлт, авалтад тогтмол хяналт тавьж ажиллав. Зааварчилгааны журналуудыг “Эрчим хүчний ажилтнуудын дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм”-нд заасны дагуу захиалан хийлгэж, ашиглаж байна. 2019 онд давхардсан тоогоор анхан шатны зааварчилгааг **625** хүн, ээлжит зааварчилгааг **37522** хүн, ээлжит бус зааварчилгааг **11983** хүн, өдөр тутмын зааварчилгааг **129921** хүн, тухайлсан зааварчилгааг **9928** хүн тус тус авч ажиллав. Мөн цаг үеийн байдал болон ажлын онцлог, дээд байгуулагаас ирсэн мэдээлэл даалгаврийн дагуу тухай бүр аюулгүй ажиллагааны ээлжит бус зааварчилгааг боловсруулан давхардсан тоогоор станцын нийт **11983** ажиллагсдад өгөв.

Тайлангийн хугацаанд үйлдвэрлэлийн осол 3 удаа гарсан.

- 2019 оны 03-р сарын 18-ны өдөр Зуух №4-ийн үнс баригч төхөөрөмжид гарсан үйлдвэрлэлийн ослын мөрөөр 14 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан. Мөн нийт ажилтнуудад ослоос урьдчилан сэргийлэх талаар АА-ны ээлжит бус зааварчилгаа өгсөн.
- 2019 оны 10-р сарын 17-ны өдөр “Таван толгой түлш” ХХК-ийн 2-р үйлдвэрийн түлш савлагааны байранд гарсан үйлдвэрлэлийн ослын мөрөөр 13 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан. Мөн нийт ажилтнуудад ослоос урьдчилан сэргийлэх талаар АА-ны ээлжит бус зааварчилгаа өгсөн.
- 2019 оны 10-р сарын 28-ны өдөр 35 кв-ын ил хуваарилах байгууламжинд гарсан үйлдвэрлэлийн ослын мөрөөр 16 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан. Мөн нийт ажилтнуудад ослоос урьдчилан сэргийлэх талаар АА-ны ээлжит бус зааварчилгаа өгсөн.

Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн акт тогтоож, НМХГ-ын Хөдөлмөрийн хяналтын Улсын байцаагчаар хянуулан баталгаажуулсан.

Өвлийн улиралд нийтийн эзэмшлийн талбай болох автобусны зогсоол, станцын төв үүднээс автозамын уулзвар хүртэлх замын цас мөсийг цех болон захиргааны ажилчдын оролцоотойгоор цэвэрлэж, хальтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлж ажиллав.

Цагаан сар угтсан их цэвэрлэгээний хүрээнд нийтийн эзэмшлийн талбай болох автобусны зогсоол, станцын төв хаалгаас уулзвар хүртэлх 50м талбайн цас мөсийг цехүүдийн тусламжтайгаар цэвэрлэлээ. Цэвэрлэгээнд нийт алба, хэлтсийн 100 гаруй ажилтан оролцож хатиргаа, гулгааг арилгаж ажиллав.

Бүх нийтийн их цэвэрлэгээ “Намар 2019”, Нийслэл хотын 380 жилийн ойг угтаж Хан-Уул дүүргийн 3 дугаар хороотой хамтран зохион байгуулав. Цех, алба, хэлтэс, хэсгүүд 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрүүдэд станцын хашаан дотор, гадна талбай нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хог хаягдлыг цэвэрлэж, зориулалтын хогийн цэгт тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн хаяж зайлуулав.

2019 оны ундны усны гэрээг “Бапаана трейд” ХХК-тай хийж, нийт 52 цэгийн ундны усны шүүлтүүрийг 3 сар тутамд солиулж, 8.9 сая төгрөгийн солилт, засвар үйлчилгээ хийлгүүлэв.

2019 онд “АПУ” ХХК-тай ажилчдын нормын сүү нийлүүлэх гэрээ хийж, Д витаминаар баяжуулсан сүүг нийт 4 алба хэлтэс, 11 цехийн хөдөлмөрийн хэвийн бус хортой нөхцөлд ажилладаг 162 ажилтанд одоогийн байдлаар 17,8 сая төгрөгний нормын сүү олгов.

Цехүүдийн ахуйн байр болон ариун цэврийн өрөөнүүдэд ариутгал, халдваргүйтгэл, шавьж мэрэгчийн устгалыг улирал тутамд “ Дархинт” ХХК-тай хийсэн гэрээний дагуу 2442,1 м2 талбайд ариутгал, 1616 м2 талбайд мэрэгч устгалыг нийт 4.8 сая төгрөгөөр хийлгүүлэв.

Цайны газрын хоолонд эрүүл ахуйн үзүүлэлт болох нянгийн бохирдол, хоолны бодит илчлэгийг МХЕГ-ын “Хүнсний аюулгүй байдлын лавлагаа” лабораторид өдрийн 16 хоол, ээлжний 4 хоолыг түүврийн аргаар авч, шинжилгээнд өгөв. Шинжилгээгээр нийт 20 хоолны эрүүл ахуйн үзүүлэлт “Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 6308:2012 стандарт”-д нийцсэн үзүүлэлттэй гарсан байна.

Цайны газарт ариун цэвэр, эрүүл ахуй, хоолны дээж авалт, устгалын хөтлөлт, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал болон хадгалалтын горимын шаардлага хангаж буйд байнгын хяналт, шалгалт хийж ажиллав.

Харуулын шалган нэвтрүүлэх цэгийн рентген төхөөрөмжийн ажлын байранд сар бүр хяналтын цацрагийн хэмжилт хийж ажиллаа.